

Өмнөх үг

Монголын нийгэмд хэзээ ч философи байсангүй. Бидэнд ганц ч монгол хүн философийнхоо номуудыг бичиж үлдээсэнгүй. Өнөөдрийг хүртэл “философи” гэ нэрлэсэн зүйлс бүгд үлгэр, домог, идэологи ба ганц хүний хувийн төсөөллүүд бас эндүүрэлүүд. Философийн нэртэй бичигдсэн номууд ч бас ганц нэг Орос хэлтэй хүмүүсийн хувийн, алдаатай бичиглэлүүд.

Өнөөдөр хүмүүс философи ихээр яриж эхэллээ. Тэдний шалтгаан гэвэл аливаа ард түмэнд философи зайлшгүй хэрэгтэйн баталгаа. Дэлхийн унивэрситэтүүдийн хамгийн ууган оюуны энэ салбар Монголд огт үгүй тул хүмүүс түүнийг хэзээ ч олохгүй хайлт. Тэр ч бүү хэл их хурлын нэг гишүүн Монголд философи хайгаад “философичид сэрцгээ” нэртээ нийтлэл хүртэл бичжээ. Тэр гишүүнд хэлэхэд “Та байхгүй зүйлийг байгаа гэж ” цагаа үржээ.

Яагаад их хурлын зарим гишүүд оюун, ухаан гэх мэт философийн сэдвүүдээс ганц нэгээр дуугарч эхлэв? Яагаад тэд хурал хийж бас зурагтаар яриж эхлэв? Яагаад гэвэл төрийн тухай мэдлэг философхоос гаралтай. Хэдийгээр ганц хоёр хүн ч гэсэн философийн тухай нийтэж яриж эхэлнэ гэдэг том биш ч гэсэн бяцхан амжилт. Гэхдээ л хэт хобби маягаар яриваал ахиц гарахгүй.

Ерөөсөө өнөөдөр Монголд философи нэрийн дор олон хүмүүс худлаа мэдээлэл цацсаар. Үүнийн жишээнүүд дараах:

1. Социализмын үеийн нийгмийн гэгдэх салбараас үлдсэн хүмүүс монголын залуучуудад философи нэрийн дор лэцц уншдаг. Гэтэл тэд өөрсдөө хэзээ ч сонгодог философичидийн номыг уншаагүй гэдэг батлагдсан. Тэдгээр хүмүүс өөрсдөө түүнийгээ хүлээдэг ба зөвхөн цалин авахын тулд худлаа яридагаа зөвшөөрдөг. Тэгсэн хэдий ч тэд цааш залуу багш нарыг төрүүлдэг. Одоо энэ хүмүүс худлаад бүр үнэмшчихсэн, зөв мэтээр яриж оюутануудад гай тарисаар. Тэдэнд мэргэжлийн философийн ном унших Англи хэл ч, Герман хэл ч, Франц хэл ч үгүй.
2. Монголын нийгэмд нэгэнт цацагдчихсан мэргэжлийн биш хобби философичидын номууд номын дэлгүүрүүдээр дүүрч зогсоохын аргагүй бас эдгээхийн аргагүй оюуны хомсдолыг гүнзгийрүүлж эхэллээ. Мэргэжлийн биш хүмүүс философи нэрийн дор мухар сүсэг, шашины улайрал, бөө зурхай, Буддизмын нагаржунай, Хятадын күнз эсвэл Түвдийн ламаизмыг сурталчилагсад. Тэд нийгмийг нэгэнт хордуулсан хаэвээр.

Философи мэргэжил болохоос биш сонирхсон хүн л мэдэмхийрдэг хобби биш. Энэ мэргэжилд сурацлах хэрэгтэй. 1000 хуудастай философийн номуудыг унших , ойлгох тийм ч хөнгөхөн асуудал биш. Тиймээс мэдлэг баталгаатай хүнийг л сонгохзөв биш үү.

“Философийн мэдээ” сэтгүүл философийг мэргэжлийн хараа хяналт дор уншигч Танд хүргэж буй.

Хүндэтгэсэн:
С.Молор-Эрдэнэ

Дугаарын хөтөч

Сэтгүүлийн энэ дугаараар эрхэм уншигч та бүхэнд өмнөх дугаарт гарсан зохиолуудыг үргэлжилүүлээ. Үүнд: М.Хэйдэггэр “Байх ба хугацаа”, Ж.Роулс “Зүйгийн тэори”, М.Понти “Мэдрэмжийн фénomэнoлог”, С.Пинкэр “Хэлний инстинкт”, Р.Давкинс “Сохор цагчин”, С.Фройд “Өдөр дугамын амидралын психопатологи”, Ф.Скиннэр “Сайэнс ба хүний төрх”, М.Нуссбаум “Зүй ба амидралын чанар” К.Маркс “Капитал”, Аристотэл “Никомахын этик”, Ф.Хэгэл “Эрхийн философи”, Г.Баумгартэн “Тэоричилсон эстетик”, П.Сартр “Байх ба юу ч биш”, Т.Хоббс “Лэвиатан”, Ф. Ницшэ “Заратустра ингэж ярилаа”.

Үүнээс гадна санал бодол буланд философич Проф. С.Молор-Эрдэний “Хобби философичид ба мэргэжлийн ном”-ийн тухай, эссэ буланд “Мэдлэгийн салбар ба Монгол орон” нийтлэгдсэн.

Өмнөх дугаарт М.Хэйдэггэрийн бүтээлээр фénomэнoлог гэж юу мөн фénomэнoлог логостой хэрхэн холбогддог тухай бичсэн бол энэ удаагийн дугаарт фénomэнoнууд тусахаас гадна хэрхэн туяардаг тухай бичсэн. Өмнөх дугаар дээр хэвлэлийн алдаанаас болоод Ж.Роулсын “Зүйгийн тэори” номын 4 бүлэг алдаатай хэвлэгдсэн учир энэ дугаарт дахин оруулав. Харин энэ дугаарт 5 бүлэг “Классик утилитаризм”-д, нийгэм хэрхэн замбараатай зүйтэй байх, хуви хүн болон нийгэмийн харилцаа онцлогийн талаар мөн этикийн хоёр гол ухагдахуун сайн ба зөвийн талаар орчуулагдсан, харин М.Понтигийн “Мэдрэмжийн фénomэнoлог” бүтээл үргэлжилж анхаарал ба ялгаварлахын талаар мөн бид мэдрэмжлэхэд анхаарал ямар үүрэгтэй, онцлогтойн талаар энэ дугаарт орчуулсан. С.Пинкэрийн “Хэлний инстинкт” номын хоёрдугаар бүлэг “Чалчаа хүмүүс”-ийн бүлэг дохионы хэлийг хэрхэн сурдаг мөн сургадаг тухай. Мөн дохионы хэлэнд анализ хийж, ямар бэрхшээлүүд гардаг мөн ярианы хэлнээс ямар ялгаатайг шинжилжээ. К.Марксын “Капитал” номоос солилцооны үнэт ба хэрэгцээний үнэт хэрхэн ялгаатай тухай энэ удаад танилцуулсан. Р.Давкинсын “Сохор цагчин” номын нэгдүгээр бүлэгийн төгсгөлөөр юмсын дизайныг Год \бурхан\ биш харин натур өөрөө дизайндсан тухай гарсан бол харин энэ дугаарт номын 2 бүлэг “Сайн Дизайн” –д сохор хүн, сарисан багваахай мөн зарим амитдын онцлогийн талаар гарна.

Ф. Хэгэлийн “Эрхийн философи” номын өмнөх дугаарт гарсан “Эрхийн философийн сууриуд буюу натурийн эрх ба төрийн сайэнс” хэмээх бүлэг үргэлжилж энэ дугаарт бодолын болон хүсэлийн ялгаа гэдэг зөвхөн тэоричилсон ба практикчилсан төрхүүдийн ялгаа. Тиймээс энэ хоёр тусдаа эзэмшилүүд биш харин хүсэл гэдэг бодолын нэг онцгой шинжийн тухай. С.Фройдын номын өмнөх гуравдугаар бүлэгээр марталтын талаар ярисан номын дөрөвдүгээр бүлэгтээ амидралын ихэнх үед бидэнтэй хамт явдаг хүүхэд насаны санамжыг анализалжээ.

Хоббсын “Лэвиатан” номын “Хэлний тухай” хэмээх 4 бүлэгт хэл хэрхэн ойлгох талаар гарна.

Ж.П.Сартрын “Байх ба юу ч биш” номын орчуулгын энэ удаагийн дугаарт Байх мэдрэмжтэй хэрхэн хамаатайг илэрхийлсэн ба биднээр мэдрэмжлэгдэж, ухаанд буусанууд л буйг гаргасан. Аристотэл “Никомахын Этик” бүтээлийн энэ удаагийн дугаарт жаргал гэж юуг хэлэх мөн жаргал эрдэм, сайн, сайхан мөн баясалуудтай

салшгүйг өгүүлсэн. Г.Баумгартэний “Тэоричилсон эстэтик” ном натураасаа өгөгдсөн чадварыг эстэтик дасгалаар хэрхэн сайжруулах тухай үргэлжилжээ. Ф.Скиннэрийн “Сайэнс ба хүний төрх” зохиол “Яагаад организмууд төрх гаргадаг вэ? Гэсэн шинэ бүлэгт хүний төрхийг физикт бие тодорхойлох уу гээд үүндээ анализ хийжээ. Мөн хүний төрх гаргах дотоод каузуудыг авч үзжээ. М.Нуссбаумын “Зүй ба амидралын чанар” номоос энэ дугаарт хүн гэж хэн бэ, ямар шинжээр хүн гэж нэрлээд буйг тодорүүлсан хэсэг орчуулагдан оржээ.

Энэ дугаарт шинээр Жонон Тэхнологийн дээд сургуули дээр бямба гараг бүр явагддаг “Сэргэн мандалт” нэрийн дор цуврал лекцийн илтгэлүүдийг оруулсан.

Мөн Зууны мэдээ сонинд хэвлүүлсэн судлаач Гансүхийн “Монголын үндсэн хуули конституц биш” гэсэн эссэг нийтэллээ.

Уншигч таны анхааралд

“ъ,ь” гэсэн илүүдэл тэмдэгүүдийг хэрэглээгүй, нэр үгийн үндэсийг алдахгүйн тулд эгшиг гээгээгүй, “е” үсэгээс татгалзсан. Харин гадаад нэрүүдийн “е”-г “э”-гээр орлуулсан.

Санал Бодол

Мэдлэгийн салбар ба Монгол орон

Үргэлжлэл.

Философи мэдлэгийн тухай ямар тодорхойлолтыг 2500 жилийн өмнөөс хэрэглэж ирсэн тухай түрүүчийн дугаарт бичсэн. Плато мэдлэгийг “үнэн зөвтгөсөн үнэмшил” гэсэн. Үүнийг бүр тодруулан “үнэн зүйжүүлсэн үнэмшил” гэж орчуулах боломжтой. Энэ бичлэгээр би мэдлэг ерөөсөө хүний мэдрэлүүдээс хэрхэн хамааралтай тухай тайлбарлана. Хүн аливаа хэргийг бодолоороо бас үзсэн үзэлээрээ нээдэг. Ингэж хүнд өдөр бүр л олон олон хэрэг учирна. Хүн бас хэрэг бүрийг хэрэгсэнэ эсвэл хэрэгсэхгүй. Тэгвэл хүн тэдгээрийг бодолоороо нээв үү эсвэл мэдрэлийн эрхтэнүүдээрээ нээв үү гэсэн хоёр асуулт хэдэн зуун жилийн түүхтэй зөвхөн философийн сэдэв. Энэ хоёроос философийн хоёр сургуули үүссэн. Нэгд: Рационализм, хоёрт: Эмпиризм.



Хари гаригийн нисдэг хөлөгүүд Америкийн хотуудын дээгүүр ниссэн тухай ярианууд бий. Тэр ч бүү хэл яг харсан гэсэн гэрч хүртэл мэдээлжээ. Хүмүүс юу хүлээдэг вэ түүнийгээ л дүрсэлжээ гэмээр.

Мэдлэг, ухамсар мөн үзэл гэсэн гуравын харицааг дүрслэхийн тулд хэд хэдэн ухагдахуунуудыг хэрэглэх шаардлага гардаг. Латины “a priori” буюу априори гэсэн ухагдахуун эртнээс буюу эртээс гэсэн утгатай. Философичид үүгээр баталгаан дээр суурилсан мэдлэгийг нэрлэдэг ба мэдрэлийн эрхтэнүүдийн үзсэнүүдийн зөвтгөл

зайлшгүй биш гэдэг. Тиймээс үзээгүйгээр эртнээс буюу уридчилан мэдэх боломжтой гэдэг. Жишээлбэл бүх ганц бие эрчүүд гэрлээгүй гэвэл хүн заавал энэ өгүүлбэрийг мэдэх гэж гадуур гүйж ганц биетүүдийг асуух шаардлагагүй. Энэ өгүүлбэрийг үнэн гэдэгийг хүн мэднэ мөн хүн өгүүлбэрийн утгыг мэднэ. Харин үүний эсрэгээр мэдрэлийн таван эрхтэнүүдээрээ зөвтгөж чадах баталгаануудыг “a posteriori” буюу апостериори гэж нэрлэдэг.

Энэ хоёрын ялгаа баталгааны үнэнийг хэрхэн зөвтгөх замыг нэрлэдэг. Гэхдээ тухайн хүн үгүүдийг мөн ухагдахуунуудыг хэрхэн эзэмшсэнтэй ямарч хамаагүй. Нэг үгээр хэлэхэд мэдлэгийнхээ баталгааг ойлгоход зайлшгүй биш. Мэдээж хүмүүс ганц бие эсвэл гэрлээгүй гэх мэт үгнүүдийн утгыг сурсан явдал чухал. Харин хүн нэгэнт л хэлсэн өгүүлбэрийг ойлгосон гэвэл үнэнийг гаргахын тулд цаашаа үзэх үзэл хэрэггүй. Тиймээс бүх ганц бие эрчүүд гэрлээгүй гэсэн мэдлэг “априори”. Мэдээж мэдлэг үзсэн үзэл дээр эхлээд суурилсан.

Дээрх хоёр мэдлэгийн төрөлүүд бас цааш “аналитикчилсан” ба “синтетикчилсэн” баталгаануудаар ялгагдана. Аналитикчилсан баталгаа тэгэхээр үгийн утгаар л үнэн эсвэл худлаа гэгдэнэ. Яагаад гэвэл ганц бие гэсэн үг аналитикчилсан тул бас априори. Гэтэл бүх априори үнэнүүд аналитикчилсан биш. Жишээлбэл хүн өөрийгөө “эксистэнц” гэдгийг априори мэдэж чадах ба гэхдээ “би байна” аналитикчилсан биш. Синтетикчилсэн баталгаа юу вэ гэхээр хэрвээ аналитикчилсан биш гэвэл. Тиймээс синтетикчилсэн баталгаа зөвхөн үгийн утгуудаар үнэн эсвэл худлаа биш гэхгүй харин “хэрэгүүдээр” үнэн эсвэл худлаа гэнэ. Жишээлбэл Исланд оронд тэмээн хяруул үгүй.

Рационализм ба эмпиризм хоёрын гол асуулт гэвэл хүн үзээгүйгээр буюу үзэлгүйгээр мэдлэгт хүрэх боломжтой юу л гэсэн асуулт. Рационалистууд батлахдаа хүн мэдрэлийн эрхтэнүүдийн оролцоогүйгээр синтетик априори мэдлэгт хүрч чадна гэдэг ба ухаанаас гадуур юмс зогсдогтой адилаар. Жишээлбэл морал, метафизик мөн материаллаг ертөнц. Эмпиристүүд үүнтэй маргадаг ба ухаанаас гадуурх ертөнцийн тухай бүх мэдлэг мэдрэлийн үзсэнүүдээс гаралтай гэнэ.

Рационалистууд мэдлэгт хүрэхдээ таван эрхтэнүүдийг хэрэглэхгүй гэсэн ойлголт бараг л зургаа дахи мэдрэл мэт нэрлэгддэг. Түүгээр хүн моралийн, математикийн мөн бусад фактуудыг нээх боломжтой.

Эмпиристүүдийнхээр бүх ухагдахуунууд зөвхөн үзсэнүүдээс л гаралтай. Жишээлбэл духан дээрээ эвэртэй мори хүмүүсийн мори ба эвэр гэсэн ухагдахуунуудын холбоос. Жишээлбэл амидралдаа өнгө хараагүй хүн улаан гэсэн өнгөний талаар ямар ч ойлголтгүй.

Рационалистууд заавал мэдрэлийн эрхтэнүүдээрээ үзэхгүйгээр ухагдахуунуудыг гаргах боломжтой гэдэг. Эцсийн эцэст бурханыг хэн ч хараагүй гэтэл хүмүүс энэ ухагдахууныг айхтар мэддэг.

Эмпиристууд мэдлэгийн салбарт дараах гурван боломжийг өгдөг:

- Хүн ерөөсөө мэдэж чадах уу гэдэгт маргалдах
- Бүх мэдлэгийг зөвхөн үзсэн үзэлээс гаралтай гэдэг
- Бүх априори мэдлэгүүдийг зөвхөн аналитикчилсан гэдэг



357 жилийн турш математикчид Пиэр дэ Ферматын “сүүлчийн тэорэм”-ийг батлах гэж ажилласан. Математикийн үнэн тэгэхээр комплэкс.

Эмпиристуудийнхээр математикийн мэдлэг том проблем авчирдаг. Гэхдээ арифметик мөн геометр хоёр ертөнцийн тухай субстанциэл мэдлэг ба түүний чанаруудыг нийлүүлдэг. Тиймээс тэр мэдлэг хэрэгтэй ба жишээлбэл байшин барихад. Гэхдээ л математик априори сайэнс. Мэдээж тэгэхээр математикийн мэдлэг эмпиризмийн эсрэг цохилт. Харин эмпиристууд математикийн мэдлэгийг хэрхэн ажигладаг вэ? Эмпиристууд математикийн мэдлэгийг априори гэдэг ба субстанциэл мэдлэг өгөхгүй гэнэ. Тиймээс математикийг аналитикчилсан мэдлэг гэдэг. Математикийн мэдлэг маш олон дэфиницүүдээр хийгдсэн жишээлбэл: 1, нэмэх, тэнцүү гэх мэт.

Тэгвэл математикаар хэрхэн шинэ мэдлэгт хүрэх вэ гэсэн асуулт гарах ба нэгэнт л дэфиницээр үнэн тул тэгээд гайхах шинэ хэрхэн гарах вэ гэсэн асуултууд тулгардаг. Математикийн үнэнүүд комплэкс ба түүнийг батлахад маш их хөдөлмөр хэрэгтэй.

С. Молор-Эрдэнэ

Эссэ

Хобби философичид ба мэргэжлийн номууд.

“Суут 60 сэтгэгч”, “Их гурвалжин”, “Хуулийн амин сүнс” гэх мэт мэдлэгтэй биш зөвхөн хоббитой хүмүүсийн хэвлүүлсэн номууд Монголын номын зах зээлийг эзэлсээр. Зүгээр л тэр хүн тэдэнд онд төрсөн, хувийн амидралын тухай таамаглалуудыг бичсэн, мөн тэр хүн ямар гарчигтай номууд бичсэн тухай он дараалалын болон намтарын цуглуулгуудыг бичиж, бодоогүй бас эрэгцүүлээгүй номуудыг залуус уншиж бас л боддоггүй, эрэгцүүлдэггүй хүмүүс болцгоосоор.

Их сургуулид ч гэсэн философичидийн төрсөн он сар, бичсэн номуудын гарчиг бас хувийн амидралын онигоотой хэсгүүдийг яриж түүнийгээ оюутнуудад цээжлүүлэн шалгалт авдаг дэндүү ядуу боловсролтой философич гэж өөрийгөө нэрлэцгээдэг хобби хүмүүс лэцц уншсаар л. Тэдгээр хүмүүсийн номууд дэлгүүрүүдээр зарагдсаар л бас худлаа лекцүүд Их сургуулийн танхимуудад уншигдсаар.

Психологийн эсвэл философийн гэсэн гарчигтай номууд ямар ч мэргэжлийн түвшинд биш бичигдэж тэдгээр номуудыг ямар ч хяналтгүйгээр тараасаар. Боловсролтой хүний төрхгүй бас моралгүй Батотгон гэх эмэгтэйн хувийн төсөөлөлүүд зөв мэт ойлгогдсоор. Баабар ч гэсэн дутахгүй өөрөө уншаагүй номуудаа дүү Доридоо уншаарай гэж захисан хэвээр. Энэ мэт хувийн зүүдүүдээ мөн захиасуудаа Монголын нийгмийн дунд цацаж бас сурталчилуулсаар. Тэдний номууд уншигдсаар бараг л үнэмшигдсээр. Энэ үнэмшилүүд нийгмийн боловсролын түвшинг тодорхойлсоор.

Философи нэрийн дор Нагаржунайгийн онол, Араг барилын онол гэх мэт мухар сүсэгийн ном бичиж олон нийтэд өөрсдийгөө гайхуулах гэсэн хоббитой философичид бас олон өвөө нар. Өвөө нар мэдлэгийн ямар ч баталгаагүй, хувийн үлэрүүдээ ярисаар л бас титэм үгнүүдээ хэлсээр л. Далан наstad даруулга хэрэгтэй гэж Монголчууд хэт хөөрсөн өвгөдөд анхааруулдаг байсан санагдана.

Хүний хөл гарыг гэмтээвэл шүүхдэж хохиролоо нөхүүлнэ эмчилгээ хийсний дараа эдгэрнэ. Тэгвэл нийхэмийн ухааныг бас залуучуудын тархийг худлаа мэдээлэл хувийн сонирхолдоо автагдан гэмтээж буй хүмүүсийг хэн шүүж хохиролыг төлүүлэх вэ. Психологийн мэргэжлийн номуудад хүний тархины нэгэнт үүссэн мөрүүдийг арилгах олон жилийн асуудал гэж бичжээ.

Дээрх ном бичих хоббитой хүмүүс юуг ойлгоогүй вэ гэхээр философийн мэргэжлийг бас оюуны салбарын мэргэжлүүдийг олон жил суралцдаг гэснийг ойлгосонгүй. Суралцах гэдэг тийм ч хөнгөн асуудал биш. Тэдгээр хүмүүсийн боловсролын түвшин юу бичиж буйгаараа амархан танигддаг. Юу ч бичээгүй гэвэл

магадгүй хүндлэгдэх байсан ч юм уу. Тэдэнд боловсролын талаар өчүүхэн мэдлэг байтугай төсөөлөл даан ч алга.

Дэлхийн университетүүдийн оюуны салбарууд гэхэд л соёл \култур\, заншил \этнолог\, сэтгэл \психолог\, хүний гарал \антрополог\, хүмүүсийн хамтрал \социолог\ мөн хамтралын түүх \хистор\ гэх мэт хүний хөгжилийн талаар бүрэн судалдаг. Монголын Их сургуули харин хүн судлахгүй нийгэм судална. Тэгээд л гүйцээ. Гэтэл дээрхи судалгааны салбарууд яг л натурын сайэнс шиг фактуудаар ажилладаг.

Тэр бүгдийн эх үүсвэр мөн цаад учруудыг философи асуудаг. Философи асуухдаа гүн асууна ба өргөн асууна. Философи эргэцүүлэлийн методуудаар ажиллана. Философичидийн бичсэн хэдэн мянган номууд бий. Ядаж ганц ч удаа гэсэн мэргэжлийн философичидийн жишээлбэл Аристотэл, Кант, Дэкарт, Хэгэл, Хюмэ нарын номыг дээрхи нөхөд уншиж толгойгоо ажиллуулах хэрэгтэй. Орос хэлээр дамжин зарим хүмүүс ном уншдаг явдал бий. Гэхдээ дэлхийд алдартай орос философич ганц ч үгүй шүү. Философичгүй хүмүүсийн хэлээр тэгээд философийн ном уншсан гэх дэндүү гэнэн бас дэндүү хариуцлаггүй хэрэг биш үү.

Оюуны салбар Европын университетүүдэд эрчимтэй хөгжиж Америкт ч гэсэн цааш улам боловсронгуйжсан. Монголд оюуны салбарын зарим эхлэл социализмын үед Оросуудаар дамжин ирсэн. Нэгэнт мэргэжлийн хүмүүс дөнгөж Оросод бэлтгэгдсэн тул тэдний яаруу эхэлсэн түүх, улс төр гэх мэт салбар ерөнхийдөө хэт номлож заасан бас цээжлүүлсэн маягаар явагдсан явдал нийтлэг. Монголчууд хэдийгээр Оросод сурсан ч гэсэн феодализмын үеийн багш шавийн харицаа оюуны салбарт үргэлжилж асуудаг бас шүүмжилдэг оюуны чухал аргууд Монголд огт ирсэнгүй.

Ардчилалын 20 жилд уншсан орос бас орчуулсан монгол ном заах биш харин зөвхөн хувийн төсөөлөлүүдээ заадаг хүмүүс Их сургуулидад олширч нийтлэгжсэн. Орос хэлтэй хөгшин багш нар давамгайлсан хэвээр. Тэдний шавиуд үргэлжлүүлэн худлааг ярисан хэвээр. Модноос унасан алим нэг их хол өнхөрдөггүй гэдэг. Тэд сэтгэлийн хөдөлгөөнүүдээ лэцц болгон ярицгаана. Их сургуулид сэтгэлдээ сэтгэсэнээ яриж, чөлөөт ярилцлага мөн оюуны хөдөлмөр хийгдэх боломж хэзээ ч үүсэж чадсангүй.

Их сургуулид философи заадаг хүмүүс яагаад философийн номуудыг зайлшгүй унших хэрэгтэй гэвэл философи маш тунгалаг илэрхийлдэг, формулууд яг бас тэдгээрийг дахин бодоход боломжтой. Философи маш дэгтэй бодол бас баттай аргументүүдийг нийлүүлдэг. Монголын Улсын Их Сургуулид амидралдаа философийн номнуудыг уншиж үзээгүй хүмүүс хэзээ ч оюуны боловсрол эзэмшээгүй хүмүүс. Тэд ямар философич хэдэн онд төрсөн бас ямар сэдвийн тухай

бичсэн гэдгийг л цээжилсэн яриа хураагч багажнууд. Багажнууд хэр хураасан түүнийгээ л цацна. Цацсаныгаа буцааж яриулан шалгалт нэрээр асууна. Энэ хүмүүс хэзээ ч бодож чадахгүй яагаад гэвэл тэд логикт суралцаагүй. Тэд хэзээ ч ярилцаж чадахгүй яагаад гэвэл цээжилсэнээс биш мэтгэлзэж сураагүй.

Философийн номуудыг Монголд мэргэжлийн түвшинд оруулж ирэх цаг нэгэнт иржээ. Монголын нийгмийг хобби философичдийн номнуудаас аврах цаг болсон. Философи нэгэнт мэргэжил тул суури мэдлэг, боловсронгуй мэдлэг бас хаана ч хүчинтэй. Философи дэлхийн али ч унивэрситэтэд хүчинтэй мэдлэгийг сургадаг. Философи зөвхөн өнгөрсөнийг дүгнээд зогсохгүй бас ирээдүйд чиглэсэн. Гэхдээ ирээдүйг таамаглахгүй. Түүний талаар нухацтай бодно. Яагаад өнөөдөр ийм “болсон” бэ бас ирээдүйд хэрхэн “байх” вэ гэдгийг асууж ойролцоогоор хариулах биш харин логиктой хариулна.

Натурын сайнс матэриаллаг биетийг судалдаг, социалын сайэнс хүн ба нийгэм хоёрыг харицуулан судалдаг тул харицангуйг нэг үгээр хэлэхэд хамаатайг тодорхойлдог. Харин философи бодох гэж юу вэ гэдгийг бас сайн гэж юу вэ гэдгийг асуудаг. Философи этикийн асуултуудыг тодорхойлж үнэтүүдийг судалдаг тул “хуманити”-ийн тэориг гаргадаг. Тиймээс философи сайн ба мууг нэг үгээр хэлэхэд сайн ба муугийн шалтгаануудыг ялгадаг. Эпистэмолог буюу танихуйн тэорид тэорэтик шалтгааныг судалдаг ба харин Этикийн салбарт практик шалтгааныг судалдаг.

Философи хүмүүс үнэтүүдийг хэрхэн үнэлж буйг асуухын тулд хүний “үйлдэл”-ийг ойлгохыг зоридог. Үүний тулд тухайн хүний мотивийг мөрдөх ба түүний мэнталын төлөвийг илчилдэг. Үүнийг ажигласнаар хүн өөрийнхөө үйлдлийн мотивац ба шийдэлийнхээ ситуацуудыг хурцаар ажиглах боломж гарна. Тиймээс философийн хараа хурц. Тэгэхээр мэдрэмж сайтай. Нөгөөтэйгүүр философи зөв ба буруу үйлдэлүүдийн критэрүүдийг гаргадаг тул аливаа зөрчилүүдийг этикийн тусламжтайгаар дүгнэх ба хүмүүсийн бодолын, үйлдэлийн мөн мэдрэхүйн ялгаануудыг судална.

Философи хүний эксистэнцийг өөрийн эмоцтой, рационалтай, културтай бас социалтай хамтруулан судлаж гэгээрүүлдэг. Ингэснээр сууритай бас баттайгаар тухайн хүний ертөнцийг харах харц мөн ертөнцийг зураглаж буй зургыг гаргадаг.

Философийн номуудыг мэргэжлийн төвшинд орчуулж чадвал тэдгээрийг анх удаагаа оюутнууд мөн ялангуяа Их сургуулийн лэцк уншигчид бие даан уншиж сурна. Ингэж уншиж сурсанаар бусадтай ярилцаж сурна, бусадтай уулзах зоригтой болно, бусдад бодолоо яриж чаддаг болно, яриж буй сэдэв хоорондоо авцалдах боломж гарна. Тиймээс философичидийн түүх бас он саруудыг цээжлэх зогсоно.

Философийн номуудыг мэргэжлийн төвшинд уншиж сурсанаар хүн зөвхөн хэлээр дамжуулан бодолоо илэрхийлж сурах биш бас юу хийх гэж буй зорисон үйлдэлээ илэрхийлж сурна. Тиймээс Их сургуулийн лэкц уншигчид оюутнууддаа юуны тухай ярих гээд буйгаа бас ном унших яагаад хэрэгтэй вэ гэдгийг сурна.

Философийн номуудыг Их сургуулийн лэкц уншигчид мэргэжлийн номуудыг уншсанаар өөрсдийн бодолтой болно, тэд зөвхөн Оросод сурч Ленинизмээр тархиа угаалгасан хүмүүсээр заалгаж бас цээжилсэнээ оюутнуудад ярих зогсоно. Хэрвээ Их Сургуулийн лэкц уншигчид философийн мэргэжлийн номнуудыг уншвал мэргэжлийн түвшинд ном бичиж сурна. Номыг ойлгомжтой бичиж сурна гэдэг тийм ч амархан биш. Ойлгомжгүй ном бичнэ гэдэг тэдгээр хүмүүс ном бичих дуртай гэхдээ мэдлэггүй шүү гэсэн ойлголт.

С. Молор-Эрдэнэ.

Монголын Улсын Үндсэн Хуули Конституц биш

“Зууны мэдээ” сонины 2010 оны 1 сарын 21. №16 \3394\

Дэлхийн улс бүр өөрийн үндэстэний конституцийг батлан тунхагладаг. Ялангуяа демократ төртэй улс оронуд хүний төлөө тул хүнийг тунхаглан конституцаа хийдэг. Гэтэл Монгол Улсын 1992 онд гаргасан Үндсэн хуулийг ажиглахад демократ төртэй улсын конституцаас эрс ялгаатай хачирхал төрүүлэх боллоо. Мэдээж монгол орон социализмийн үед төрөө дээдэлсэн Үндсэн хуультай байсан үнэн. Тэгвэл өнөөдөр демократ гэж нэрлээд байгаа бол Монгол Улс Үндсэн хуулиа хэдийд конституц болгох юм бэ гэсэн асуулт зайлшгүй гарч ирэх ёстой. Үүний дараагийн асуулт бол демократ улсуудын конституцийг замбараагүй шилж сонгон орчуулсан хүмүүс Үндсэн хуули гэж нэрлээд буй монгол хүний төлөө биш хуулиудын цуглуулгаа хэзээ засаж залруулах гэж байна. Эцэсийн эцэст хэн нэг хүн мэдэмхийрч Үндсэн хуулийг яаран гаргаж, өөрийнхөө нэрийг мандуулахдаа биш. Хамгийн чухал ни монгол хүн монгол нутагтаа нэгдүгээр зэрэглэлийн хүн байх ёстой шүү гэдэгийг тунхагласан Монгол Хүний Тунхаг л бидэнд зайлшгүй хэрэгтэй.

Тиймээс өнөөдөрийн Үндсэн хуулийг шүүмжтэйгээр авч хэлэлцэж, дэлхийн утгаараа конституц болгохын тулд дараах хэд хэдэн алхамуудыг хийх зүйтэй болов уу гэж энэ нийтлэлийг бичлээ.

Тэгвэл конституц гэж юу вэ? ямар утга агуулгатай ба тустай вэ? Энэ ухагдахуун латин гаралтай үг ба гарган тавих ба байгууллага гэсэн утгатай үг. Хуулийн утгаараа тунхаг. Энэ тунхагын цаад утга төрийн мэдэл иргэний суури эрхүүдтэй уялдан хийгдэх ёстой л гэсэн ойлголт. Энэ ухагдахуунаар Эртний Ромын эзэнт гүрэнд чухал хуулийг тэмдэглэж байсан. Соён Гэгээрэлийн үеэс хойш конституц хуулиас илүү тунхагийн шинжтэй болсон. Өнөөдөр ч ийм л утгаар хэрэглэгдэж байна. Аливаа демократ улс конституцаа эзэн болсон иргэнийхээ төлөө зориулж хийдэг. Тэгэхээр монголын конституц монгол хүний төлөө хийгдэх ёстой. Конституц үндэстэний туйлын хүсэлийг илэрхийлэл ба тухайн нийгэмийнхээ үнэтүүд болон нийгэмийн суури принципүүдийг нэрлэдэг. Эдгээр суури принципүүд туйлын ба өөрчлөгдөшгүй. /өөрчилж болохгүй/. Конституцууд мөн хүний эрхүүдийг агуулдаг ба төрийн мэдэлийн хуваарилалт, бүтэц, үүрэг, процедурыг тусгадаг. Хамгийн чухал зүйл болох суури политикин принципээ тодорхойлдог. Хэрэв конституцаа өөрчилж, суури принципүүдээ зөрчिवөл хохирогч улс, үндэстэн бүхэлээрээ байх болно. Иргэн хүний амидрал доройтож, төр авилгалд идэгдэж, улс орон тогтворгүй болно. Аливаа хуулийн суури Конституц болдог ба конституцаа бариж л хуули гардаг бөгөөд хамаагүй хуули гаргаж хүний амидралыг бусниулаад байж болохгүй. Демократ нийгэмд иргэн хүн конституцаар хамагаалагддаг ба дээдлэгддэг.

Конституцийн талаар философичид эртнээс нааш өнөөдрийг хүртэл бодож, түүнийг бичсээр иржээ. Эртний Грекийн философич Плато, Аристотэл, Ромын Цицеро нар конституцийн талаар бичиж байсан. Аристотэл тухайн үеийн хот

улсуудын хуули ба конституцийг системтэйгээр судалжээ. Тэрээр өөрийн “Политик” зохиолдоо конституцийн талаар: “Хамгийнсайн конституц зайлшгүй ямараар хийгдэх вэ гэхээр хүн бүрт хамгийнсайн өгөгдөхөөр” байх ёстой хэмээн бичсэн байдаг. Тэрээр сайн амидрал хэдхэн элитүүдэд эдлэгдэх биш харин нийгмийн бүх гишүүдэд олгогдох ёстой гэсэн. Соён Гэгээрэлийн үеийн философичид конституцийг маш чухалчилан авч үзэж шинэ шинэ идэйгээр баяжуулсан. Конситуц энэ үеэс хуулиас илүү тунхагийн шинжтэй болсон. Томас Хоббэс, Самуэл Раторфорд, Жон Милтон, Жон Локкэ, Ш. Монтэскэе зэрэгийг нэрлэж болно. Францын хувисгалын дараанаас эхлэн эдгээр философичидийн идэй бодит амидрал болж, олон улсууд өөрийн үндэстэний конституцийг батлан гаргасан.

Үүнээс хойш өнөөдөрийг хүртэл дэлхийн тусгаар тогтносон бүх улс өөрийн конституцийг батлаад байна. Монгол Улс өөрийн конституцаа 1992 онд баталсан бөгөөд үүнийгээ демократ Үндсэн хуули гэдэг. Аливаа демократ улс бүр Конституцаа батлахын өмнө Соён Гэгээрэлийн үеэс гаралтай ба Францын хувисгалын уриа болсон Демократ нийгэмийн суури принципүүдийг баривдаг ба дээдэлдэг. Энэ бол али ч демократ улсын нийгэмийн суури болдог ба энэ зайлшгүй байх ёстой. Эдгээр принципүүд юу вэ гэвэл: Freedom /Амгалан/- эрх чөлөө хэмээн ташаа орчуулдаг. Аливаа хүний ба нийгмийн амгалан байдал хууличилагдсан эрх ба чөлөөгөөр биелэгддэг ба конституцаар хамаагаалагддаг байна. Хамгийнгол ни хүн баталгаатай, амгалан, тайван амидралаар амидрах. Equality /Тэнцүү/ - Хүн бүр ямар ч ялгаваргүйгээр бүгд тэнцүү гэсэн санаа. Хууийн өмнө бүгд адил ба шийтгэл ч, шагнал ч адил. Мөн бүх хүн адил эрхтэй. Нийгэмд хүний тэнцүү байдал чөлөөттэй / Liberty/ харшилдах тохиолдол гардаг ба энэ үед үүрэг ба хариуцлагаа ухамсарлаж тэнцүүт чөлөөтийн өмнө тавивдаг. Fraternity /Анд/ - энэ монголд орж ирээгүй. Хүн бүр танихгүй ч байсан бие биедээ ахан дүү, андууд шиг харицаж, хандах ёстой гэсэн идэйг агуулдаг. Хүн бүр бие биенээ хайрлаж байж л дээрхи хоёр биелэгдэх боломжтой. Харин ардчилалыг оруулж ирэгчид нийгэмийн суури принцигийг ойлгоогүй ба буруу бичсэн. Монголын демократ нийгэмийн суури принцип Монголын Демократ намын байрны өмнөх чулуун дээр бичээстэй байдаг. Тэнд Эрх чөлөө, шударга ёс, эв нэгдэл гэж бичсэн ч эдгээр ни харамсалтай ни буруу. Эв нэгдэл /solidarity /- дайсагнасан хоёр талын эвлэрүүлэхэд л хэрэглэдэг. Энэ ни социалист нийгмийн суури болон хэрэглддэг.

Дээрхи демократ нийгэмийн гурван принципүүдийг тус тусад салгаж болохгүй ба заавал хамт байх ёстой. Мөн али нэгийг илүүд үзэж, дээгүүр тавих ни хортой.

Эдгээр суури принципүүдыг хоосон лоозогнох биш харин бодит амидрал болгох ни хамгийнчухал. Тиймээс суури принципээ тодорхойлчихоод Конституцаа хийдэг. Тэгэхлээр конституц юунд чиглэгдэх вэ гэхээр хүн бүр амгалан, тэнцүү байж, бие биетэйгээ ахан дүү шиг, андууд шиг харицан амидрахад чиглэгдэх ёстой. Энэ бол нийгэмийн хамгийнүнэт хэсэг. Харамсалтай ни монголд ардчилалыг оруулж ирэгчид болон Үндсэн хуулийг

хийгчид үүнийг ойлгоогүйгээс болж монголын нийгэмийг сууригүй, тогтворгүй болгожээ.

Сууриа тавилгүй монголчууд Үндсэн хуулиа /конституц/ хийсэн. Үндсэн хуулийг хийхэд гол ролид тоглосон хүмүүс хууличид. Аливаа конституцийг тухайн улс үндэстэний оюуны чадвартай хүмүүс буюу философчид хийдэгээс биш хууличид хийдэггүй.

Конституцийн гол агуулга юу вэ? Демократ улсын конституц бол хамгийн нэгдүгээрт улсын эзэн болсон хүнийг тунхагладаг ба тухайн үндэстэний туйлын хүсэл, тэмүүлэл болон нийгэмийн үнэтүүдийг тодорхойлдог. Үүнийг дараа Хүний эрхүүд, Төрийн мэдэлийн хуваарилалт болон Иргэн ба Төрийн харицааг тэнцвэржүүлэн эрхжүүлэхээр тусгадаг.

Хүний эрхүүд бол универсал ба натурал зүйл бөгөөд хүний эксистэнцийг тодорхойлж өгдөг. Хүний эрхийн өнөөдөр баримталж буй тунхаг 1948 оны 12 – р сарын 10 батлагдсан “Хүний Эрхийн Универсал Тунхаг”. Дэлхийн нийтээрээ баримталж буй энэхүү тунхагт нийт 30 зөвтүссэн. Тэдгээр хүний эрхүүдийг хооронд салгаж болохгүй бөгөөд хоорондоо нягт холбоотой хэрэглэгддэг ба дотороо иргэний, политикийн, экономийн /эдийн засаг/, социалын, соёлын хэмээн ангилагддаг. Харин манай Үндсэн хуулинд хагас дутуу л туссан.

Хүний эрхүүд хүн бол эрхэм гэсэн соён гэгээрэлээс гаралтай үзэл дээр тулгуурладаг ба хүний энэхүү эрхэм байдлыг хамагаалж баталгаажуулахын төлөө хүний эрхүүд гардаг. Хүний эрхүүд бол хүний л сайн амидрахад л чиглэгддэг ба нөгөө талаар хүний суури эрхүүдээр төрийн мэдэлийг хязгаарлахад бас чиглэгддэг.

Монгол Улсын Үндсэн хуули хийгчид Хүний эрхийг дараах байдлаар ойлгожээ. Б.Чимэд “Үндсэн Хуулийн мэдэлэг” /УБ 2008/ номын 94 –р хуудсанд “ Хүний зөвгэдэг ни төрөлхөөс заяасан бөгөөд хамгийнэгэл утгаараа хүнд өөрт байдаг, нийгэмийн дотор заавал эдлэх боломж мөн” гэж тодорхойлжээ. Үнэндээ аливаа хүн хүний эрхтэй төрөх байтугай дуудуулах нэр ч үгүй төрдөг. Аливаа улсын төр бүр монголын төр ч мөн адил Олон улс, НҮБ-ын өмнө хүний эрхийг дээдлэхээр үүрэг хүлээсэн. Тиймээс л хүний эрхийг улс бүр хамгаалахыг хичээдэг. Монгол ч мөн адил. Хүний эрхээ эдэлж чадахгүй байгаа хүнийг хүний амидралаар амидарч байна гэж дүгнэхэд хэцүү.

Аливаа демократ улсын эзэн мэдээж хүн, монгол улсын эзэд монгол хүн байх ёстой. Тиймээс монголын Үндсэн хуули /Үнэндээ бол Конституц/ монгол хүний төлөө хийгдсэн байх ёстой. Гэсэн ч Үндсэн хуулийг хийгчид монгол хүнийг монгол улсын эзэн хэмээн тунхаглаж зүрхэлсэнгүй. Тэд төрөө дээдэлсэн социалист үзэлээсээ салж чадаагүй ба тэдэнд шинэчлэл явагдсангүй. Монгол хүний төлөө конституц байсан бол монгол улсын эзэн монгол хүн тиймээс монгол хүний төлөө хэмээн тунхаглаад монгол хүний эрхүүдээр эхлэх байсан. Дэлхийн али ч демократ улс ийм л байгаа. Гэвч монгол хүнийг дээдлэх байтугай харин ч малнаасаа үнэгүй болгосон байна. Үндсэн хуулийн Нэгдүгээр бүлэгийн 5-5 –д “Мал сүрэг бол Үндэсний баялаг мөн бөгөөд төрийн хамагалалтанд

байна” гэжээ. Монгол хүнийг дээдлэх байтугай хамагаална гэсэн ямарч заалт алга.

Манай Үндсэн хуулинд хэдэн зөвхөрхэн туссан талаа дээрхи номын 106 –р хуудсанд “ Үндсэн зөв, чөлөөтийг Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлд арван найман хэсэгээр бүлэглэн заасан байна. Хүмүүс 1-18 гэсэн дугаарыг харчихаад л “иргэн 18 эрхтэй” гэж бичээд бас “үүрэг ни цөөдөж” гэж шүүмжилээд байдаг. Дотрохыг ни уншилгүй шүүмжилэх ч гоомой хэрэг. Арван наймын зөвхөн нэг хэсэгт арав гаруй эрхийг нэрлэн заасан ч бий” хэмээжээ. Энэ юу вэ? ингэж бараа бөөндөж байгаа юм шиг бөөндөж болох уу? Яагаад улс бүр хүний эрхийг нэг нэгээр дэталчлан авч үздэгийн учирыг энэ хүмүүс даан ч ойлгосонгүй. Хүний эрхийн заалт бүрийн хүний амидрал байгааг сайн ухамсарлах хэрэгтэй.

Тэд хүний эрхийн заалт бүрийг маш нарийн боловсруулах ёстой байсан. Тэд маш их алдаа хийсэн. Жишээлбэл: Үндсэн хуулийн хоёрдугаар бүлэгийн 16-1 –т: “Хүн амид явах эрхтэй” гэсэн заалт бий. Энд тэд ухагдахууны алдаа гаргасан, юу гэвэл английн life гэсэн амидрах гэсэн үгийг амид гэж буруу орчуулсан. Энэ зөвбол Английн философич Жон Локкийн гаргасан иргэний гурван эрхийн нэг. Тэрээр иргэний “Амидрах, чөлөөт, өмчлөх” гэсэн эрхийг анх гаргасан. Энэ зөв “Хүний Зөвийн Унивэрсал Тунхаг”-ийн 3-рт “Хүн бүр амидрах, чөлөөтэй байх, хамагаалуулах эрхтэй” гэжээ. Али ч демократ улсын конституцад энэ зөвбий. Энэ бол зөвхөн ухагдахууны алдаа биш. Аливаа хүнийг амид явах эрхтэй гэж байгаа бол гудамжины, траншаны хүмүүс зөвни биелэгдэж байгаа юм байна. Амитанд ч гэсэн амид явах зөв бий. Гэвч хүн бол амитанаас ялгаатай бөгөөд амидардаг. Монгол хүнийг амитадтай адилдгажээ. Хүнд амидрахын тулд дараах зүйл /хамгийннаад зах ни / шаардлагатай. үүнд: “Идэх хоол, өмсөх хувцас, дулаан байр, эрүүл агаар, цэвэр ус, гэр бүл цэцэрлэгийн хүмүүжил, сургуулийн боловсрол, хөдөлмөр”. Энэ л зүйлүүд хангагдсан үед хүн амидрах эрхээ эдэлж байна гэж ойлгож болно. Үүнийг төр хангах ёстой бөгөөд төрийн нэн тэргүүний үүрэг байх ёстой. Ийм алдаа зөвхөн нэг заалтан дээр биш бүх заалтан дээр байна..

Ингэж аливаа конституцын амин чухал хэсэг болох хүний эрхийг монголын Үндсэн хуули тусгаж чадсангүй.

Дараагийн нэг чухал зүйл бол төрийн мэдэлийн хуваарилалт бөгөөд аливаа улс бүр конституцдаа хатуу зааглаж, эрхийг зүйгээр тэнцүүлдэг. Мөн политикин суури принципүүдээ хатуу тогтоож өгдөг. Үүнд төрийн мэдлийг Executive /хуули хэрэгжүүлэгч/ Legislative /хуули хийгч/, Judicial /хуули тайлбарлах/ эдгээр төрийн гурван баганийг анх Францын философич Ш.Монтэскэе боловсруулсан. /хооронд ни үүргий ни ялгахын тулд хуулиар жишээ авав/ Тэрээр шүүхийг эхний хоёроос хараат бус биеэ даасан байх ёстойг онцолсон байдаг. Энэ хуваарилалт дэлхийн али ч демократ улсад хэрэглэж байгаа. Ингэж хуваах ни төрийг хянах л зорилготой. Монголд Executive –ийг гүйцэтгэх засаглал, Legislative –ийг хуули тогтоох засаглал , Judicial –ийг шүүх засаглал хэмээн нэрлэдэг. Энэ талаар Б.Чимэд “Үндсэн хуулийн мэдлэг” /УБ

2008/ номын 178 –р хуудсанд “Executive – буюу гүйцэтгэх мэдэлд Засагийн газар / төрийн гүйцэтгэх дээд байгууллага / Ерөнхийлөгч - /төрийн тэргүүн бөгөөд монголын ард түмэний эв нэгдэлийг илэрхийлэгч / -ийг, Legislative буюу хуули тогтоох мэдэлд Улсын Их Хуралийг /төрийн эрх барих дээд байгууллага мөн бөгөөд хуули тогтоох мэдэлийг гагцхүү УИХ эдэлнэ/, Judicial буюу шүүх мэдэлд Үндсэн хуулийн цэц /Үндсэн хуулийн манаач/ , Дээд шүүх / Монгол улсад шүүх мэдэлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ/ тус тус хамааруулсан байна./хаалтанд үүргийг ни оруулав/

Эдгээр ни тэнцүү эрхтэй байх ёстой. Харамсалтай ни эсрэгээрээ бөгөөд эндээс монгол улсыг парламентын засаглалтай гэж хэлэхэд хэцүү. Хуули тогтоохоос бусад ни хоёр хоёроороо хосолчихож, харин парламент ганцаараа. Харин мэдэлийг ни харвал шүүх засаглалтай эсвэл гүйцэтгэх засаглалтай улс гэмээр. Үнэндээ бол ийм засаглалтай улсыг дэлхийн хаанаас ч олохгүй. Ингэж мэдэлийг нарийн хуваарилж чадаагүй ба хоорондийг үүргийг зааглаж чадаагүйгээс болж нэг гарт хэт мэдэл төвлөрөх, хоорондоо хэт ойртож холбогдох гэх мэт байдал үүсэж, төрийн тогтвортой байдал алдагдаж байна.


Төрийн мэдэлийг хуваарилж чадаагүй үед сүүлийн асуудал болох төр иргэн хоёрын харицааны тухай асуудалыг ярих боломжгүй, нэг талд хүчтэй, данхайсан монгол хүний төлөө биш төр нэг, нөгөө талд мэдэлгүй, үнэгүй ядуу монгол хүн л байна. Монгол хүний төлөө биш төр хуули гаргаж иргэдээ шоронд хийж, цэрэг хөдөлгөж иргэдээ буудна. Хүний эрхийг дээдэлдэггүй, дарангуйлагч төртэй улсыг демократ улс гэж нэрлэх үү. Ардчилал бол хоосон уриа биш бодит амидрал байх ёстой. Монголын үндсэн хуули гэсэн энэхүү баримт бичиг Хүн төрөлхтний хэрэглэж буй конституцтай нэрний, хэлбэрийн, агуулгын хувьд тохирохгүй байна. Хамгийнгол ни конституцийн амин сүнс Монгол улсын Үндсэн хуулинд алга. Хоорондоо ямарч логикгүй, бусад орнуудын хуулийн цаглуулга л байна. Монголын Үндсэн хуули монгол хүний амидралын баталгаа ч болж чадахгүй хамагаалж ч чадахгүй. Конституц бол хуули биш. Харин хуулийн тулгуур.

Монгол улсын Үндсэн хуули бол Конституц биш. Яагаад гэвэл монгол хүний төлөө хийгдээгүй. Монгол хүн монгол нутагтаа хамгийннэгдүгээрт байх ёстой. Үүнийг л тусгасан конституц одоо монголд хэрэгтэй. Конституцаа батлаагүй бол хүний эрх, ардчилалын тухай, цаашилаад хөгжил дэвшилийн тухай ярих боломжгүй.

Монголын Ухаан Судлалын Хүрээлэнгийн судлаач: Б.Гансүх

Аристотэл

\Aristotle\



Никомахын Этик

Үргэлжилэл...

9. Жаргалын тухай түүн дээр нэмэлтгүйгээр бүгдийг хэлсэн мэт тусна. Зарим жаргалыг эрдэм гэнэ бусад хувийн л харц шүү дээ гэнэ, гуравдагч цэцэний нэг төрөл гэнэ. Тэднээс бусад энэ бүгдийг нэг бол дуртай холбож тайлбарлана, харин зарим холбохгүй. Зарим хүмүүс бас гадаад амгаланг нэрлэнэ. Энд яриж буйнууд эртнээс олон хүмүүсээс гаралтай ба зарим цөөхөн алдартай хүмүүсээс гаралтай. Энд яриж буй жаргалын тайлбарууд али ч бүрэн дутаагаагүй ба тэдний бага хэсэг ихэнхдээ зөв.

Жаргалыг эрдэм гэх эсвэл эрдэмүүдийн нэг гэж тодорхойлдог хүмүүс бидний сургаалтай нийцнэ. Яагаад гэвэл эрдэм эрдэмлэгдсэн үйлдэлүүд гэдэгээр тооцогддог. Тиймээс хүн хамгийн сайныг эзэмшил гэнэ үү эсвэл үйлдэл гэнэ үү эсвэл түүнийг нэг төлөвт оруулна уу эсвэл түүнийг нэг ажилд хамааруулна уу ямарч ялгаагүй мэт. Яагаад гэвэл төлөв сайныг гүйцэлдүүлээгүй ч цаашид тогтоно. Жишээлбэл хүн унтах эсвэл ямарч ажил хийхгүй. Гэтэл ажиллана гэвэл дээрх боломжгүй. Яагаад гэвэл ажил зайлшгүйгээр үйлдүүлж мөн сайнаар үйлдүүлнэ. Жишээлбэл Олимпийн тоглолтын үед хамгийн хөөрхөн, хамгийн чадалтай түрүүлэхгүй харин хэн тэмцсэн тэр түрүүлнэ. Түүнтэй адил зөв үйлдсэнүүд амидралын сайхан болон сайн юмсыг хождог.

Ийм утгаараа амидрал амтлахад баян. Яагаад гэвэл амтлах сүнсний юмст хамаардаг ба хүн юунд татагдсан сэтгэлтэй вэ түүгээрээ ханамжийг авна. Жишээлбэл хурдан моринд дуртай хүн моринд татагдана, жүжиглэх дуртай хүнд жүжигчиний ажил таалагдана. Үүнтэй ижилээр зүй зүйд дуртай найзад татагдана мөн ерөөс эрдэмлэх эрдэмтэн найзад татагдана. Мэдээж хүмүүст амттайнууд зөрчилтэй. Яагаад гэвэл сайханд дуртай натураасаа харин амттайнууд натураас амттай. Үүнтэй ижил эрдэмтэй үйлдэлүүд. Эрдэм тухайн тэр хүнд амттай. Ийм хүмүүсийн амидрал заавал нэг зүйлийн дурыг шаардахгүй. Харин тэр дурыг хайх шаардлагагүй яагаад гэвэл тэд бидэнд өөрсдөд бий. Үүн дээр шижир үйлдэлдээ хүн баярлахгүй гэвэл тэр бас л сайн биш. Яагаад гэвэл зүйтэй үйлдэлдээ баярлахгүй хүнийг хүн түүнийг зүйтэй хүн гэж нэрлэхгүй. Өгөөмөр үйлдэлдээ баярлахгүй хүнийг өгөөмөр гэж нэрлэхгүй. Тиймээс эрдэмтэй үйлдэлүүд өөрөө амттай.

Шижир хүмүүс сайнаар ялгаврласан гэвэл дээрхүүд сайн бас сайхан мөн бүрэн онц. Тиймээс тэр бидний хэлсэнээр л ялгасан.

Тиймээс жаргал гэдэг хамгийн сайхан хамгийн баярлууштай бөгөөд тэднийг салгаж боломжгүй. Яг л Дэлос-ын ишлэлд-д¹ бичсэн шиг салгаж болохгүй. Энэ бүгд хоорондоо хамаатайгаар хамгийн сайн тооцогдоно. Энэ үйлдэлүүдийн хамгийн сайныг бид жаргал гэж нэрлэдэг.

Дээрх бидний хэлсэнээр мөн гадаад сайнуудад шаардлагатай. Жишээлбэл шижирийг хийхийн тулд аливаа нэг багажгүйгээр боломжгүй ба тийм ч амар биш. Яагаад гэвэл хүн биелүүлэхийн тулд нөхөд, баялаг, политикийн мэдэл хэрэгтэй ба нэг үгээр хэлэхэд эдгээрийг хэрэгсэл болгодог. Нөгөөтэйгүүр хүнд зарим юмс дутагдалаа гэвэл жишээлбэл цол, удам угсаа, гоо гэвэл жаргал сулрана. Мэдээж гадаад үзэмжээрээ дэндүү муухай царайтай гэвэл. Үүнтэй ижил дотоод гаралтай ганцаардмал, огт хүүхэдгүй хүмүүсийг ч мөн жаргалтай гэхгүй. Эсвэл золгүйтсан хүүхэдүүдтэй эсвэл найзуудтай гэвэл жаргалтай гэж нэрлэхгүй. Үүнтэй ижил сайнаар ханддаг байсан хүмүүс үхчисэн бол жаргалтай гэхгүй. Ингээд зарим хүмүүс жаргаасан тохиолдолыг жаргалтай солидог ба мөн эрдэмтэй ч солидог.

10. Эндээс ямар асуулт гарах вэ гэхээр жаргалыг хүн сургаж, дасгаж эсвэл бусад дасгалуудаар эзэмшүүлэх боломжтой юу? Мөн түүнийг бурханы хувиарлалтаар болон жаргал тохиолдон эзэмших боломжтой юу? Гэсэн асуулт гардаг. Хэрэв түүнийг хүмүүст өгсөн бурханы ямар нэг бэлэг гэвэл жаргалыг бурханаас өгөгдсөн гэнэ. Ингэж илүүтэйгээр жаргалыг хүмүүсийн сайнуудын дотор хамгийн сайн гэдэг. Гэхдээ үүнийг ондоо шинжилгээгээр гаргаж ирэх болов уу. Харин бурханаас өгөгдөөгүй гэвэл эрдэмээр, нэг төрөлийн сурлагаар эсвэл дасгалаар хийгдсэн гэмээр ба хэрэв тийм гэвэл ёстой л бурханлаг үйлдэлээр хийгджээ гэмээр. Эрдэмийн үнэ ба зорилго хамгийн сайн гэмээр ба бурханлаг бас ариунлаг гэмээр. Тиймээс жаргал дээрх төрөлөөр олон хүмүүст хүрэх боломжтой. Тиймээс ямар нэг сургалтаар болон халамжлалаар түүнд хүрэх боломжтой. Харин эрдэмд энэ замаар хүрэхгүй.

Хэрэв гэнэтээр биш харин дээрхээр жаргалд илүү гэвэл үнэхээр л тийм гэдэгийг хүлээн авах хэрэгтэй. Яагаад гэвэл натураасаа юмс хамгийн сайн гэдэгээрээ л үлдсэн ба үүнтэй ижил урлаг ч бүх шалтгаанууд ч бас хамгийн сайнууд ч хийгдсэн. Хамгийн томыг, хамгийн сайханыг гэнэтэд даалгана гэдэг дэндүү хөнгөмсөг.

Дээрх хариунууд бидний бодолоос гаргалгаатай. Яагаад гэвэл жаргал сүнсний эрдэмтэй үйлдэлүүдийн нэг төрөл гэдэгээр тодорхойлогдсон. Үлдсэн сайнуудаас али нэг зайлшгүйгээр оролцох ёстой ба харин бусад багаж гэдэгээрээ тусладаг мөн ашигтай.

Энэ бүгд анх хэлсэнүүдтэй таарна. Яагаад гэвэл бид тэнд политикийн урлагыг хамгийн сайн гэж нэрлэсэн. Тийм л урлаг ихэнхдээ иргэнийг тодорхой эрдэмд сургадаг ба хамгийн шижирийг хийхэд чадваржуулдаг.

Хамгийн утгатайгаар амитадад жишээлбэл үхэрт, моринд жаргалтай гэсэн нэр өгдөггүй. Яагаад гэвэл тэдний али ч иймэрхүү ажилыг хийдэг. Яг л үүнтэй ижилээр бага хүүхэд ч гэсэн жаргалтай гэж хэлэгдэхгүй. Яагаад гэвэл наснаасаа шалтгаалан жаргалын төлөө хүүхэд юу ч хийхгүй. Хэрэв хүүхэдийг жаргалтай гэж хэлбэл түүнийг зөвхөн найдсандаа л хэлж буй.

¹ Дэлос-эртний Грекээр шижир, гэрэлтсэн гэсэн утгатай ба Грекийн нарны бурхан, Аполло бурханын төрсөний тухай өгүүлдэг Грек домог.

Бидний хэлсэнээр жаргалд төгс эрдэм мөн төгс амидрал шаардлагатай. Хүний амидралд олон өөрчлөлтүүд, олон гэнэтүүд учирна. Мөн хамгийн сайнаар амидарч буй хүн хөгшин насандаа жаргалгүйтэлд унах боломжтой. Яг л Троианы эпост² өгүүлдэгтэй адил. Хэн иймэрхүү гэнэтийг эдэлж, жаргалгүйгээр төгсөнө түүнийг хэн ч ариуссан гэхгүй.

11. Тэгвэл хүнийг амидрах үед ариусгахгүйгээр Солоны³ хэлдэгээр зөвхөн төгсгөлийг хүлээж, харах ёстой гэж үү? Хэрэв тийм гэвэл хүн үнэхээр үхэж буйгаараа л жаргалтай гэж үү? Эсвэл жаргалыг бид ямар нэг төрөлийн ажиллах ажилаар тодорхойлно гэх бүрэн утгагүй гэж үү? Хэрэв бид үхсэнүүдийг жаргалтай гэж нэрлэхгүй \үүнийг Солон ч мөн хэлсэн\ гэвэл зөвхөн муугаас хол мөн бусад жаргалгүйнүүдээс хол хүнийг ариусгана гэвэл энэ бас л өөрийн гэсэн проблэмтой. Яагаад гэвэл үхсэн хүнд ч сайн ба муу өгөгдсөн гэмээр. Мөн амидарч буйнууд ч гэсэн хүүхэдүүдийнхээ хүндэтгэл ба бузар мөн үе залгамжлагчийнхаа тайван ба жаргалгүйг мэдрэхгүйгээр сайн эсвэл муу өгөгдсөн гэмээр гэтэл энэ бас өөрийн гэсэн хүндрэлтэй. Хэн нэг хүн хөгшин болтолоо жаргалтай амидрах боломжтой ба мөн түүгээрээ үхэх магад. Гэтэл түүний үе залгамжлагчид олон өөрчлөлтүүдийг үзэх ба зарим хичээнгүй мөн түүндээ таарсан амидралаар амидрана. Гэтэл бусад түүний эсэргээр. Юу тодорхой вэ гэхээр тэд ээж ааваасаа ялгаатайгаар янз янзаар амидарцгаана. Тиймээс үхсэн ээж аав одоогын үр удамынхаа өөрчлөлттэй нэг бол жаргалтай нэг бол жаргалгүй гэх утгагүй. Мөн үүнтэй адил юу утгагүй вэ гэхээр одоогийн үрсийн хуви заяа үхсэн ээж аавынхаа нэрийг баллана гэвэл бас л утгагүй. Тэгсэн ч одоо бүгдээрээ өмнөх асуултдаа буцаж очий. Тэндээс магад одоогийн асуулт хариулагдах болов уу. Хэрэв хүний төгсгөлийг харна гэвэл мөн түүний дараа хүн бүрийг ариусгана гэвэл яагаад гэвэл тэр одоо ариусгагдсан биш учираас харин одоо түүний жаргалтайгын тухай үнэнийг хэлэхгүй гэвэл утгагүй. Яагаад гэвэл амидарч буйнуудыг тэдгээрийн өөрчлөлтүүдээр үнэлэхгүй гэвэл жаргалыг нэг тогтсон зүйл ондоогоор хэлбэл амархан өөрчлөгдөхгүй гэвэл жаргал гэдэг нэг л хүнд олон дахин эргэлддэг бус уу? Яагаад гэвэл бид жаргалыг дагахыг хүсвэл тухайн хүнийг үргэлж нэг бол жаргуулна үгүй гэвэл жаргуулаагүй гэж нэрлэнэ. Ингэж нөгөө жаргалтай хүн нэг төрөлийн хамэлон⁴ болох ба ингэсэнээрээ эрүүл биш суурин дээр тогтоно. Тэгвэл ерөөсөө жаргалын араас хөөцөлдөх буруу бишүү? Яагаад гэвэл тухайн хүн дотор сайн ба муу бий биш. Харин бидний хэлсэнээр хүний амидралд жаргал шийдвэрлэх үүрэгтэй ба харин жаргалд юу шийдвэрлэх үүрэгтэй вэ гэвэл эрдэмтэй ажилууд.

Бидний тодорхойлолууд дээрхийн хүчинтэйнүүдийг тусгасан. Яагаад гэвэл хүмүүсийн хийсэн үйлдэлүүдийн дотор эрдэмтэй ажил шиг тогтвортой зүйл өгөгдөөгүй. Эрдэм мэдлэгээс илүү тогтвортой мэт. Эрдэмүүдийн дотороос хамгийн тогтвортой дээд зэрэглэлтэй яагаад гэвэл жаргалтайнууд түүн дотор олоноороо мөн удаан амидардаг. Тиймээс дээрх яагаад мартагдаагүй вэ гэдэгийн шалтгаан. Бидний хайж буйнууд тэгэхээр жаргалтайнуудын дотор олдсон ба тэр хүн амидралын турш тийм. Яагаад гэвэл тэр хүн бусдаас илүүгээр эрдэмтэйгээр үйлдэх ба бас бодно.

² Троиан- Трои хааны дайны тухай өгүүлдэг эртний Грекийн поэмуудын \том хэмжээний шүлэг\ цуглуулга.

³ Солон- эртний Грекийн философич

⁴ Хамэлон- гүрвэлийн төрөлийн өнгөө хурдан хувиргадаг амитан.

Заяагаа тэр сайханаар мөн хармонитойгоор⁵ тээнэ. Тэр үнэнээр сайн ба өөгүй дөрвөн өнцөгттэй адил.

Яагаад гэвэл том жижиг ч янз янзууд гэнэт тохиолддог тул юу тодорхой вэ гэхээр жижиг жаргалтай тохиолдолууд мөн түүний эсрэгүүд амидралд тийм ч чухал биш. Харин том болон ихүүд эгзэг таарсан гэвэл тэр амидралыг жаргалтай амидрал гэнэ. Яагаад гэвэл тийм жаргал амидралыг чимдэг ба түүнийг ашиглана гэдэг сайхан бас хүндтэй. Хэрэв үүний эсрэг гэвэл жаргалыг үрэх ба булингартуулна. Яагаад гэвэл өвдөлт авч ирэх ба ихэнх ажилуудыг саатуулна. Гэхдээ тухайн хүн болон том жаргалгүйг тээдэг ч тухайн хөгжилтэй гэвэл ийм хүний шижир булингарыг нэвтрэн гэрэлтэнэ. Гэхдээ энэ мэдрэмжгүй гэдэгтээ биш харин тэр хүний эрхэм болон оюунлагаас гаралтай.

Хэрэв хүмүүсийн ажил амралыг шийддэг гэвэл бидний хэлсэнээр жаргалтайнуудын хэн ч ариусагдахгүй биш. Яагаад гэвэл биш тэр хэзээ ч үзэн яддагуудаа эсвэл муу муухайнуудыг хийхгүй. Бидний хэлсэнээр үнэнээр сайн мөн ойлгомжтойнуудын төрөл заяагаараа сайнаар явагдана гэвэл мөн өгөгдсөн нөхцөл бүрд үргэлж сайныг хийдэг гэвэл яг л хичээнгүй дайны талбарын удирдагч цэрэгээ дайнд зөв удирдаж мөн гуталчин өгөгдсөн ширээр хамгийн сайхан гуталыг хийдэг гэвэл жаргалтайнууд хэзээ ч ариусагдахгүй гэж хэлэхгүй. Гэхдээ л тэднийг төгс ариусагдсан гэхгүй ба яг л Приамусын⁶ заяа таарсан гэвэл.

Жаргалтай тийм ч амар хувиран, тийм ч хөнгөн өөрчлөгдөхгүй. Яагаад гэвэл тэр жаргалаасаа тийм ч амар мултрахгүй. Тиймээс али нэг жаргалгүйгээр мултруулахгүй. Харин илүү их, илүү том жаргалуудаас жаргалаасаа мултрах магадгүй. Мэдээж ийм үед тэр тийм ч хурдан жаргалтай болохгүй харин удаанаар магад бүрэнээр жаргахгүй боловуу. Хэрэв тэр том бас сайхан юмст очсон гэвэл.

Тэгвэл эрдэмийн төгс эрдэмээр ажилладаг мөн гадаад сайнуудаар төхөөрөгдсөн хүнийг жаргалтай гэж нэрлэхэд юу саад болох вэ? Хэдийгээр тэр хүн богино хугацаанд биш амидралын турш гэвэл. Эсвэл тэр хүнийг ирээдүйд ингэж амидрана мөн үүгээрээ л үхэх ёстой гэхүү? Гэтэл ирээдүй бидэнд нуугдмал. Тиймээс жаргалыг зорилгоо бас төгс гэж нэрлэсэн ч? Хэрэв тийм гэвэл амидарч буйнуудын хэнийг бид жаргалтай гэж нэрлэх вэ гэхээр дээрх нэрлэсэнүүд таарсан гэвэл мөн таарна гэвэл? Тэднийг бид хүн гэдэгээр жаргалтай гэж нэрлэнэ.

Ингээд энэ бүгд тодохойлогдлоо. Үр удам болон бүх найзуудын заяанууд ерөөсөө хамаагүй гэдэг хайргүй мэт тусна. Мөн ерөнхий хүмүүсийн харцанд эсрэг мэт. Яагаад гэвэл учралууд мөн олон төрөлийн ялгаатай тул нэг хэсэг бидэнд хамаатай нөгөө хэсэг бидэнд хамаагүй. Тиймээс бид юмсыг дэндүү нэг бүрчлэх, уридчилан харах боломжгүйтүүлнэ. Тиймээс бид ерөнхийгөөр хүрээгээр ярих хангалттай.

Хэрэв бид учирдаг жаргалгүй явдалуудаас амидралдаа тодорхой жин бас утга өгвөл бусадууд хөнгөхөн тусах мэт. Хэдийгээр бүх найзуудтай адилхан харицсан ч гэсэн. Харин тэр ялгаа амидарч буйнууд болон үхсэнүүдэд заяасан гэвэл Хэдийгээр бүх найзуудтай адилхан харицсан ч гэсэн. Харин тэр ялгаа амидарч буйнууд болон үхсэнүүдэд заяасан гэвэл мөн энэ заяанууд трагедуудад гэмт болон аймшигтай үйлдэлүүдээс илүү том гэвэл эсвэл тэдгээр үйлдэгдсэн гэвэл хүн бас л энэ ялгаануудыг тооцоолох хэрэгтэй ба ямар асуулт гарах вэ гэхээр тэр явцгаасанууд ямар нэг сайнуудад эсвэл түүний эсрэгт оролцох уу гэсэн асуулт гарна. Яагаад

⁵ Хармони-аятай

⁶ Пиабус- эртний Грекийн Трой хотын хаан

гэвэл энд хэлсэнүүд сайн гэвэл тэдэнд нэвтэрсэн гэхдээ дараагаар сулхан гэвэл нэг үгээр хэлэхэд өөртөө эсвэл бусдад эхлээд үгүй дараагаар том мөн тийм төрөлийн гэвэл нэг үгээр хэлэхэд тэдгээр мөн гэхдээ жаргалтай болгохгүй гэвэл тэдгээр магад мултарсан. Энд туссанаар явцгаасануудад найзуудын жаргалын болон жаргалгүйгийн явдалууд хамаатай мэт ба үүнээс ондоо гэвэл тэднийг ариусгаагүйнуудад тооцно.

Үргэлжилэл бий...

Монгол ухагдахууны тайлбар:

Ариуссан-проблэмгүй, хүсэлгүй болсон хүн.

Жаргал-жаргасан сэтгэлгээ, жаргаж сэтгэх гэхдээ азтай гэдэг аз жаргал биш.

Э. Алтаншагай

Onto_shagai@yahoo.com

Надад өөрчилөх боломжтой
зүйлийг өөрчилөх зориг хайрлаа ч.
Надад өөрчилөх боломжгүй
зүйлийг орхих тэвчээр хайрлаач
Энэ хоёрыг ялгаж чадах
ухаан хайрлаач.

Томэс морэс



А. Г. Баумгартэн
A. G. Baumgarten



“Тэоричилсон эстэтик”

Бүлэг 3

...Үргэлжилэл

§47. Амжилттай эстэтикчийн төрөлд эстэтикээр дасгаллах хүсэл, адилхан үйлдэлүүдийг үргэлж давтах бэлтгэл хамаарна. §28-46 дүрсэлсэн чадваруудын хармонууд, оюуны болон тухлагийн хармонууд биелэгдэх ёстой. Тэгсэнээрээ тодорхой сэдэвээр бодолд ондоогоор дүрслэгдэх боломж гаргах хэргтэй бөгөөд хатуу сургаалчид Орбилусын сэдэвүүдэд тавигдах ёсгүй. Ингэснээр сайханаар бодох чадвар аажимаар эзэмшигдэх боломжтой.

§48. Натураасаа өгөгдсөн буюу төрөхөд өгөгдсөн чадварууд богинохон хугацааны дотор адилхан түвшинд явагдах боломжтой. Хэрэв энэ чадварууд үргэлжийн дасгалуудаар дасгалжуулагдахгүй гэвэл дээд түвшинээсээ доошилж буурах ба хөшдөг. Гэхдээ би энд хоёрдугаар бүлэгт ярисан чадваруудын дасгалуудыг хэлээгүй зөвхөн эстэтик дасгалуудыг хэлсэн. Зарим дасгалууд сайхан өгөгдөлүүдийн натурыг ч муутгах ба илжирүүлнэ. Үүний дараа идэвхтэй болон үргэлжийн зүтгэлтэй сургаалчидын халдварт өртөж илүү сайнуудыг зөвлөх хүмүүс дутагддаг.

§49. Би энд эстэтикийн дасгалуудад болон бусадад тодорхой хармониг шаардана. Өөрөөр сайхан талэнтийн⁷ амжилт боломж үгүй ба яагаад гэвэл тэд хүчийг дэмждэггүй. Миний шаардлага бол зөвхөн хармони. Цэрэгийн ёсолж мэндлэх түүнээс боловсрол шаардахгүй харин тэмцэл шаардана. Би сайхан талэнтуудыг муутгадаг дасгалуудыг зөвшөөрнө. Би бас дисхармоноос илүү хармонийг эзэмшсэн зарим хувисалуудыг зөвшөөрнө. Түүнийг бид утгаар эстэтикчилсэн гэж нэрлэдэг. Би сайханаас илүү гутмаар зонхилсон гэвэл түүнд зориулан гутмаар дасгалуудыг зөвшөөрнө.

⁷ Talent-Юмыг сайнаар хийх натурын чадвар

Үндсэн нөхцөлийн тухай конкрэтоор үзэж буй түүний зөвтгөл өөр бас нэг талтай. Үүний тулд шалгах шалгалт бол сонгох гэж буй суури горимууд бидний уридчилан бодсон зүйгийн тухай төсөөлөлүүдэд тохирч байна уу мөн цаашид өргөтгөсөн байдалд таарч тохирох уу гэдгийг шалгах. Хүний тодорхойлсоноор бол дээрх суури горимуудын хэрэглээ нийгэмийн суури байгуулалтуудыг хэрхэн ялгаж салгах вэ гэдэгт хүргэх ба бид түүнийг одоо интиутив мөн өндөр үнэмшилээр авдаг. Нөгөөтэйгүүр бид эргэлзсэн болон татгалзсан байдлаар ялгаварлах үед дээрх суури горимууд эргэцүүлэн бодсоны дараа зөвшөөрөх шийдлийг олгох ёстой. Зарим асуултуудын хариу бидэнд нэг бол тийм нэг бол ийм гэсэн мэдрэмжүүдийг төрүүлдэг. Жишээлбэл: Шашныг тэвчихгүй мөн арис өнгөний үзэлээс болж гадуурхагдах зэрэг зүй биш гэдгийг бид батална. Бид бас дээрх асуултуудыг анхааралтайгаар судалсан мөн хэний ч талд орохгүйгээр өөрийнхөө дүгнэлтийг өгсөн гэдэгт үнэмшилтэй. Энэ үедээ бид өөрийн сонирхолоо нуун дарагдуулаагүй гэдэгийг өгүүлэх хэрэгтэй. Дээрх үнэмшлүүд бидэнд зүйгийн тухай төсөөлөлд тохирсон анхны төвлөрөх цэгүүдийг олгодог. Гэтэл бид баялаг болон мэдэл хэрхэн зөвөөр хуваарилагдах вэ гэдэгт дэндүү багаар баттай байдаг. Магадгүй энд бид өөрсөдийнхөө эргэлзээг алга болгох методийг хайх ёстой. Тиймээс бид үндсэн нөхцлийг конкрэтоор шалгахдаа түүний суури горимууд хэрхэн бидний үнэмшилтэй тохирох вэ мөн бидэнд шаардлагатай үед хэрхэн заавар өгөх зэргийг шалгах хэрэгтэй. Дээрх ситуацуудыг конкрэтоор үзэхийн тулд хайж буй хайлт төгсгөлөөс хоёулангаас эхлэх. Хамгийн эхлээд тайлбарлахдаа бид тэднийг ерөнхийдөө зөвшөөрөгдөхөөр мөн боломжийн хирээр сулхан нөхцөлд хангалттайгаар тайлбарлана. Цаашлаад бид шалгахдаа дээрх нөхцөлүүд хүчтэй гэдэгийг шалгана тэгснээрээ тэндээс суури горимуудын тривиалчлагдаагүй систем гарах ёстой. Хэрвээ энэ бүтэхгүй бол цаашлаад бид бас л адил ухамсартай уридчилсан нөхцөлүүдийг хайна. Хэрвээ энэ бүтэх бол мөн бидний сайн бодсон

зүйгийн тухай төсөөлөлүүдэд тохирсон суури горимууд өгөгдвөл энэ сайн. Гэвч тэдгээр нилээд зөрүүнүүдийг өгөх магадлалтай. Үүнийг бид хоёр маягаар хийнэ.

Нэг бол бид язгуур нөхцөлийнхөө конкретчилол болон өөрсөдийнхөө өнөө үеийн үнэлэлт дүгнэлтээ өөрчлөх яагаад гэвэл бидний одоогийн төвлөрч буй цэгүүд хүчингүйдэж болох. Бид ингэж нааш цааш хөдлөн нэг бол гэрээний ситуацынхаа нөхцөлийг өөрчилнө. Эсвэл өөр байдлаар бид өөрсөдийнхөө үнэлэлт дүгнэлтээ хийхээ болиж тухайн суури горимуудад али болох тохирно. Ингэснээрээ бид эцсийн үндсэн нөхцлийн конкрет руу очих бөгөөд энэ ухамсартай нөхцөлүүдийг үүсгэж суури горимууд руу аваачих ба ингэж бидний уридчилан бодсон үнэлэлт дүгнэлттэй тоохирно. Энэ төлөвийг би бодолын тэнцвэр гэж нэрлэв. Энэ ямар тэнцвэр вэ гэхлээр бидний суури горимууд болон, бидний ялгаварладаг үнэлгээнүүд тохирч буй тэнцвэр. Энэ бидний бодолын тэнцвэр бөгөөд яагаад гэвэл бидний мэдэхээр бидний ялгаж буй үнэлгээ ямар суури горимуудад таардаг мөн тэр ямар уридчилсан нөхцөлөөс үүсэлтэй вэ гэдэгийг мэднэ. Одоогийн агшинд энэ бүгд замбараандаа орсон. Гэхдээ л тэнцвэрт байдал зайлшгүй стабил биш. Магадгүй гэрээний ситуацуудад зориулсан нөхцөлүүдийн тухай шинэ тохиролцоонууд дээрх тэнцэтгэлийг унагаана. Мөн үүнтэй адил зарим ганцаарчилсан нөхцөлүүд бидний ялгах үнэлгээг өөрчлөх магадтай. Гэхдээ л бид чадах бүхнийгээ одоохондоо хийсэн ба социал зүйгийн тухай ерөнхийлөх болон баталгаажуулах төсөөлөлүүдээ хийсэн. Бид ингэж үндсэн нөхцлийнхөө конкрет руу очлоо.

Мэдээж би энэ бүхий л процедуруудыг бүгдийг зохион явуулахгүй. Тэгсэн ч миний энд гарган тавиж буй үндсэн нөхцлийн конкретчлолыг бодолын алхамуудын гарсан хариу гэж төсөөлөх боломжтой. Энэ бүгд суури горимуудад зориулсан ухамсартай философчилсон нөхцөл бөгөөд мөн түүнчлэн бидний уридчилан бодсон зүйгийн тухай ялгааг хамтруулан нэгэн схэмд оруулах гэсэн оролдлого. Би ямар ч үед анхны гарааны ситуацаа конкретчилох замдаа эвидэнцэд чиглэхгүй, ерөнхий төсөөлөлүүдэд чиглэхгүй мөн тусгай үнэмшилүүдэд чиглэхгүй. Энд яриж буй зүйгийн тухай суури зарчмыг зайлшгүй үнэн гэж би батлахгүй. Мөн тэндээс эх авж болох үнэн гэж ч батлахгүй. Зүйгийн тухай төсөөлөлүүд суури горимуудын уридчилсан эвидэнт нөхцөлөөс эх авахгүй харин түүний оронд өөрийнхөө зөвтгөлүүдийг олон субэктийн санаануудын харилцан түшилцлээс эх авсан ба тэгснээрээ бүгд нэгэн тэорид нэгдэх .

Сүүлчийн тэмдэглэгээ.

Бид тодорхой зүйгийн тухай суури горимууд зөвтгөгдөх боломжтой яагаад гэвэл бүгдээрээ тэгш гэсэн үндсэн нөхцөлд хүмүүст зүй гэдэгийг зөвшөөрдөгийг хэлэх ёстой. Би энд харин үндсэн нөхцөлийн цэвэр гипотез характэрийг дуридсан.

Тиймээс яагаад гэсэн асуулт бидэнд ойр хэрвээ дээрх тохиролцоонууд моралийн ч бай эсвэл өөр суури горимууд ч байсан ч үнэхээр тохиролцоонд хүрэхгүй үүний хариулт бол бид хэрэг дээрээ анхны төлөвийг тайлбарлахад хэрэгтэй нөхцөлийг зөвшөөрдөг. Хэрвээ бид зөвшөөрөхгүй гэвэл магадгүй философийн ойлголтууд бидэнд тусална. Гэрээний нөхцөлийн али ч талуудад шалтгуудтай. Бид суури горимуудын бүхий л нөхцөлүүдийг нухацтай бодсоны эцэст бүгд нэгэн төсөөлөлд хүрнэ шүү дээ гэдэгийг таних явдалыг хэлэх ёстой. Энэ нөхцөлүүд нийгэмд хамтран ажиллахад фэйр дүрэмүүдийн хязгаарлалтууд бий гэдгийг зөвшөөрөхөд бэлэн. Нэг талаас харахад анхны төлөвүүдийн тухай бодолууд нэгэн дүрслэл мэт тэр тухайн нөхцөлүүдийг утгуудыг хамтатгасан мөн тэдгээрийн тухай дүгнэлт гаргахад тустай. Нөгөөтэйгүүр энэ интуитив төсөөлөл бөгөөд түүгээр бид нарийвчлан харахад боломжтой ба мөн нөхцөлийг тодруулахад биднийг шахдаг тэгснээрээ бид тэдгээрийн моралийн холбоосыг ойлгох боломжтой. Бидэнд ямар төсөөлөл хэрэгтэй вэ гэхлээр алсад буй зорилгыг алсаас харуулах төсөөлөл хэрэгтэй. Тэр бидэнд анхны төлөвийг интуитив төсөөлөхөд чухал үүрэг гүйцэтгэнэ.

5. Классик утилитаризм

Утилитаризм³⁵ дотороо олон төрөлтэй бөгөөд түүний тэори сүүлийн жилүүдэд улам л боловсронгуй болж хөгжсөн. Энд би тэр бүх төрөлүүдийн тухай ярихгүй мөн шинээр үүссэн дискусуудын хэр нарийн чанд явагдсан тухай ярихгүй. Харин би зүйгийн тухай тэориг боловсруулна.

Энэ тэори утилитарист бодолыг ерөнхийдөө орлох алитэрнатив бөгөөд тэгсэнээрээ түүний бусад олон төрөлүүдийг орлох алитэрнатив. Миний бодолоор гэрээний тэори болон утилитаризм хоёрын олон субэктийн ялгаа дээрхитэй адил. Тиймээс би зүйг фэйрнэс гэж буйгаа бусад бидний таних интуиционизмын³⁶, пэрфекционизмын³⁷, утилитаризмын хэлбэрүүдтэй жиших. Түүгээрээ би али болох энгийн замаар гол ялгаануудыг гаргаж тавина. Энэ зорилгынхоо дагуу би утилитаризмыг чанд классик сургаалиар дүрслэх хамгийнтод болон хөнгөхөн орох боломжтой формул гэвэл философич Сидвэкийн³⁸ гаргасан формул. Түүний гол санаа бол хэдийд нийгэм замбараатай бас зүй вэ гэхлээр хэрвээ түүний гол институцууд нийгэмийн бүхий л гишүүдэд хамгийнх ханамжийг бий болгох үед. Бидний ажиглалтаар зарим нийгэмүүд ухамсартай гэдэгээсээ илүү утилитарист зүйгийн тухай төсөөлөлүүдийг харуулдаг. Хэн ч гэсэн алдагдалаа нөхөж ашиг

³⁵ Utilitarianism-үйлдэл али болох их хүмүүст али болох их жаргалыг өгөх ёстой гэсэн тэори

³⁶ Intuitionism-интуицээр дүгнэгдэж мэдэгдсэн этикийн принципүүдийн тэори

³⁷ Perfectionism-Юмсыг пэрфект (төгс) хийх сургаал

³⁸ Английн философич

олохын тулд өөрийнхөө сонирхолын дагуу ажиллах эрхтэй. Магадгүй хүн өнөөдөр хохирсон ч хэзээ нэгэн цагт харин ашиг олох гэсэн зорилготой. Ганц хүний хувид бол энэ мэдээж боломжтой хэрвээ бусдыг хохироогоогүй гэвэл. Тэр хүн али болох л хичээж али болох л ухамсартайгаар зорилгоо биелүүлэхийн төлөө. Яагаад нийгэм иймэрхүү маягаар ажиллаж болохгүй вэ гэхлээр өөрөөр хэлбэл яагаад нэг хүнд бүтсэн субэкт олон хүнтэй нийгэмд бүтэхгүй вэ? Ганц бие хүн өөрийнхөө янз бүрийн зорилгод хүрэхийн тулд амидралдаа өөрийн гэсэн хүсэлээ зохиодог. Яг үүнтэй адил нийгэмүүд хүмүүсийнхээ хүсэлүүдийг биелүүлэхийн тулд зохиох ёстой. Ганц хүнд бол дараах суури зарчим бий: өөрийнхөө таатай байдалд али болох бүгэдийг зориулах, хүсэлээ хангах. Харин нийгэмд ямар вэ гэвэл: олон хүмүүсийн тухийг али болох дэмжих, хүсэлүүдийг али болох нийтээр хангах. Ганц бие хүн одоогийн болон ирээдүйнхээ ашиг болон алдагдалуудыг нөхдөг шиг нийгэмүүд янз бүрийн иргэдийнхээ таатай болон таагүй байдалуудыг нөхөх ёстой. Эндээс ямар санаа натурайн зарчимын хувид гардаг вэ гэхлээр ашигтайгийн принцип: хэдийд нийгэм ашигтай вэ гэхлээр институцууд али болох ашигийнхаа нийлбэрүүдийг максим болгох. Тэнд олон хүмүүсийн шийдсэн дүрэмийг ганцаарчилсан хүмүүсийн шийдсэн дүрэмийн өргөтгөл гэдэг. Социал зүй гэдэг бол хүмүүсийн тухтай амидралын төсөөлөлийг нийт нийлбэр гэсэн ухамсартайгаар санаа тавих.

Дээрх санаанууд цааш бодсоны эцэст нилээд үнэмшилтэй болох ёстой. Этикийн хоёр гол ухагдахуун бол нэгдүгээрт зөв бөгөөд хоёрдугаарт сайн.

Энэ хоёроос л моралийн хувид үнэт хүний тухай ойлголтыг гарган тавидаг. Этикчилсэн тэорины структур дээрхи хоёр суури ухагдахуунуудыг хэрхэн тодорхойлсон болон тэдгээр хоорондоо хэрхэн холбоотойгоос хамаардаг. Хамгийнэнгийн харицаа тэлologiesийн тэориг гаргадаг мэт: сайн зөвөөс хамаатай бишээр тодорхойлогдоно. Харин зөв сайныг максим болгох гэдэгээр тодорхойлогдоно. Яг хэлэхэд: институцууд болон үйлдэлүүдийг хэдийд зөв гэдэг вэ гэхлээр тэдгээр өгөгдсөн боломжоос али болох их сайныг гарган авах. Өөрөөр хэлбэл наад захдаа рэал боломжуудтай институцууд болон үйлдэлүүдийн сайнуудтай тэнцүү хэмжээнд сайныг гарган авах. Тэлologiesийн тэоринууд интиутивээр нилээд үнэмшилтэй яагаад гэвэл тэд ухамсрын тухай идэйг бүрдүүлдэг. Эдгээр рационалители максим болгоход оршино. Харин морал дотор сайнуудыг максим болгоход оршино. Хэрэг дээрээ бол юмсыг үргэлж л сайн субэкт гаргаж зохиож болно гэсэн санаа бол тийм ч амар биш.

Энд бид мэдэх чухал зүйл бол тэлologiesийн тэори дотор сайн бол зөв гэдэгээс тусдаа тодорхойлогдсон. Энэ хоёр утгатай. Нэгдүгээрт энэ тэори бидний сайн гэсэн нухацтай бодосон ялгах чадварыг хэлнэ. Ингэж бидний ялгах чадварыг өөрийн

гэсэн класс болгож буй бол нийтэд интуитивээр танигдах ёстой. Ингэснээрээ сайнуудыг максим болгох зөв. Хоёрдугаарт энэ тэори тухайн субэкт сайныг ялгаж харин тэр үедээ зөвийн тухай ярихгүй. Хэрвээ тухтай гэдэг бол цорын ганц сайн гэвэл тухтайг хүмүүс таниж мөн түүнийгээ хэрхэн үнэлэхээ мэднэ. Тиймээс зөвийн тухай киритэрүүдийг ярих шаардлаггүй. Хэрвээ сайнуудыг хуваарилахдаа бараа гэдэгээр үзвэл дээрхи тэори боломжийн хирээр сайнуудыг ихэсгэхийг хэлж буй. Ингэснээрээ тэлологийн ойлголт энд яригдахгүй. Хэрвээ зөв гэдэг ухагдахуунаар хуваарилалтын проблэмийг ойлгох гэвэл дээрхи тэори дотор сайны тухай тодорхойлолтыг оруулаагүй. Класс болгож буй тэлологийн тэоринуудын гэгээтэй болон энгийн талууд биднийг моралийн хувид ялгах чадвараа хоёр класст ангилахыг хэлдэг. Нэг бол өөрөө өөртөө тодорхойлогдсон харин нөгөө бол максимал болохтой хамаатай.

Тэлологийн тэори сайны ухагдахууныг хэрхэн тодорхойлж буйгаараа олон янзын. Хэрвээ түүнийг хүн хүмүүсийн чадвар гэдэгээр янз бүрийн культуруудын төрөлүүдээр авч үзвэл бид түүнийг пэрфэксционизмтой хамаатайгаар ярих. Иймэрхүү төсөөлөлүүдийг Аристотэлийн болон Ницшэгийн номнуудаас олж болно. Хэрвээ сайныг тух гэж тодорхойлох бол тэнд бид хэдонизмын³⁹ тухай ярина. Хэрвээ бид жаргалтай жаргал үгүй гэдэгээр тодорхойлвол эвдэмонизмын⁴⁰ тухай ярих. Ашигтайгийн тухай принципийг би класс гэсэн форумд оруулж буй бол сайныг хэрэгцээнүүдийг хангах хангамж гэж буй бөгөөд магадгүй түүнээс ч илүүгээр ухамсарт хэрэгцээнүүдийн хангамж гэсэн. Эдгээрийг али ч талаас харсан тохирдог ба минийхээр бол гол интэрпритац. Нийгэмд хамтран ажиллаж буй хамтрал хэдийд гэдэгээр тодорхойлогдох вэ гэхлээр тухайн нөхцөлд хүмүүсийн ухамсарласан хэрэгцээнүүдийг али болох ихээр хангахыг хэлнэ. Үүнийг эхлээд харахад ойлгомжтой бас үнэмшилтэй. Тиймээс хэн ч үгүйсгэхгүй.

Утилитарист зүйгийн тухай төсөөлөлүүдийн нэг хачин шинж гэвэл бүх л хангамжуудын нийлбэр ганцаарчилсан хүмүүст хэрхэн хуваарилагдах тэр асуудал ямар ч үүрэг гүйцэтгэдэггүй. Нөгөөтэйгүүр тухайн хүн оногдсон хангамжуудаа хугацааны хувид хэрхэн эдлэх тухай хэлдэггүй.

Энэ хоёр төрөлийн али алинд хуваарилалт гэдэг бол али болох ихээр ханахыг хэлнэ. Аливаа нийгэм өөрийнхөө сайнууд болох эрхүүд, үүрэгүүд, бололцоонууд болон бусад олон төрөлийн тансаг амидрахад чухал хэлбэрүүдийг хэрхэн хуваарилах вэ гэхлээр боломжийн хирээр бүгд л ихийг хүртэх тиймээс ханамжинд төвлөрсөн хуваарилалт бусад хуваарилалтаас илүү талтай. Хэрвээ хүмүүсийн дунд нэг их

³⁹ Hedonism-Баясал болон жаргал амидралын цорын ганц эсвэл үндсэн сайн гэж үздэг доктрин

⁴⁰ Eudaimonism-этикийн зорилго хувийн сайн сайхан ба жаргалтай байх гэж үздэг тэори

ялгаа үгүй бол тэгш хуваарилалт илүү. Эндээс харахад зүйгийн тухай сонирхолтой эсрэг санаанууд гарч буй учир зүйгийн тухай төсөөлөл хүмүүсийн эрхийг болон фрийдомийг хамгаалахын эсрэг ойлголт гарч ирж буй. Гэхдээ л утилитарист хандлага хүмүүсийн ханамжийг ихэсгэх гэсэн үзэлээс нэг их зөрөхгүй бол цаашид хандлага ажээ. Зүйгийн тухай дүрэмүүд ч гэсэн али болох л ашигтайгаар бүгдэд ашигтайгаар хийгдэх зорилготой. Тиймээс нэг бол нөгөөгөөсөө илүү гэж үзэх ямар ч шалтгаан үгүй. Цөөнхийн фрийдомийг зөрчсөнөөр олонхийн тансаглалыг зөрчинө гэсэн ойлголт биш. Үнэндээ бол олонхийн тансаглалын төлөө цөөнхийн фрийдом хасагдах гэсэн шинж байдал цивилизацаар хөгжсөн орнуудад тохиолддоггүй. Зүйгийн тухай дүрэмүүд хүмүүс өөрийнхөө ашгийн төлөө зүй биш байдлыг үүсгэж болохгүй гэдэг. Гэхдээ л үүнийг утилитаристууд моралийн суури зарчимуудын хамгийн нэгдүгээрт тавихыг алдаа гэдэг. Хуви хүн өөрөө өөрийнхөө ханамжийг биелүүлэхийн төлөө явах бол ухамсартай үйлдэл байдагтай ижил нийгэм бүр иргэдийнхээ ашгийг ихэсгэхийн төлөө явах шаардлагатай.

Утилитаризмын хамгийн натурийн шинжтэй зам бол нийгэмийн гишүүн бүрт ухамсартай шийдэл явагдах ёстой гэсэн гол принцигийг хуулбарлах . Тиймээс хэний ч талыг барихгүй ажиглагчийн хувид болон өөрийнхөө мэдрэмжийг илэрхийлж буй хүмүүсийн хувид утилитарист бодолыг түүхээс хамааруулан ойлгоход хялбар. Яагаад гэвэл нийгэм дэх хүн бүрийн ухамсартай шийдэлийг сонгох гэсэн принципүүд хүмүүс али ч талыг бариагүй шүү бас хүмүүс бусдын оронд өөрийгөө тавиж бодсон шүү гэсэн төсөөлөлүүдэд тогтоно. Тиймээс энэ ажиглагчийг бусад бүхий л хүмүүсийн шаардлагатай нийцүүлэн нэгэн нэгдсэн систем болгох ба тэр л олон хүмүүсийг нэгэн бие хүн мэтээр үзнэ. Али ч талыг барихгүй ажиглагч бол хамгийн идэвхтэй төсөөлөх болон сэтгэх чадвартай. Мөн энэ хүн бусдын шаардлагыг яг өөрийнхөө шаардлагатай адил гэсэн ухамсартай хүн тиймээс ийм хүмүүс тухайн систем дотор шаардлагуудын жингийн харицааг барих ба тэдний шаардлагыг мөн идэвхтэй хуули гаргагч социал системийн дүрэмүүдээр ихэсгэх зарчимтай. Энэ шийдэл бол ердөө л үйлдвэрийн дарга үйлдвэртэй хэрхэн хөрөнгө оруулалт хийх вэ мөн ердийн худалдан авагч өөртөө хэрхэн ашигтай худалдаа хийх вэ гэсэн зарчимуудтай адил. Али ч тохиолдолд тухайн хүн өөрийнхөө хязгаарлагдмал барилуудаараа шаардлагаа хангана гэсэн ойлголт. Тэгэхлээр хамтын шийдэл гэдэг бол арга барилаа хэрхэн зөвөөр хэрэглэх вэ гэсэн ойлголт. Иймэрхүү нийгэмийн хамтын ажил хөдөлмөрүүд бол тухайн нийгэмд амидарч буй нэг бүрчилсэн хүмүүсийн шийдэл гаргах принципүүдийг тэлдэг. Ингэж али ч талыг баривчдаггүй бусдыг сэтгэдэг ажиглагчийн хувид бүхий л хүмүүс нэг л хүн шүү дээ гэсэн нэгдсэн үйлдэлд хүргэдэг. Утилитаризм тэгэхлээр нэг бүрчилсэн хүн бүр янз бүрийн шүү гэдэгийг чухалчилдаггүй.

Монгол ухагдахууны тайлбар

Зөв - юу зүйтэй, сайн, тохиромжтойгийн дагуу байхыг хэлнэ

Сайн- моралийн эрдэмүүдийг болон онцуудийг эзэмших

Үргэлжилэл бий...

Sanchir788@yahoo.com

Марта Нуссбаум (Martha C.Nussbaum)

ЗҮЙ БА САЙН АМИДРАЛ

... Үргэлжилэл

4. Сайны тухай эрчимтэй вагэ концэпц

Хэрэвээ бид сайныг урдуурчилах гэвэл бидэнд сайны тухай концэпц хэрэгтэй. Энд харин либэралчууд эргэлздэг. Яагаад гэвэл сайны тухай биечлэн төсөөлсөн төсөөлөл бүр политикчсон бодол руу оруулдаг. Зарим төсөөлөлүүдийг хэтэрхий нэг талын инструменталчилж түүнийг шийдсэн иргэд л авч харин бусад юу ч үгүй хоцордог шүү дээ л гэдэг. Иймэрхүү концэпцууд патрианал. Яагаад гэвэл тэдгээрийн тэндэнц амидралын зарим шинж төрхүүдийг дэмжиж, заримыг дэмждэггүй. Түүнээс гадна либэралчууд Аристотэлчуудын сайныг биечилж буй өөрөөр хэлбэл субстанцалж буй шийдэлийг хүмүүсийн суури төсөөлөл гэж буй метафизик хандлагатай гэсэн. Яагаад гэвэл сайны тухай иргэд янз бүрийн төсөөлөлтэй бөгөөд тиймээс политикин зөвшилцөлд хүрэх чадваргүй гэдэг. Тиймээс аристотэлчууд юуг харуулах ёстой вэ гэхээр сайны тухай ухагдахуун ямар агуулгатай мөн хаанаас гаралтай болохын хувид ямар нөлөөтэй вэ гэдгийг харуулах ёстой.

Аристотэлчуудын сайны тухай концэпц Роуллсын сул тэоритай адил сулхан биш. Яагаад гэвэл тэр хүмүүсийн сайн амидралд хэрэгцээтэй олон төрөлийн хэрэгсэлүүдийг тоочдоггүй. Харин хүмүүсийн амидралын янз бүрийн салбарт буй хүмүүсийн амидралын зорилгуудыг тодорхойлдог. Энэ концэпц эерэг утгынхаа хувид нилээд таамаглаж буй. Энэ юу гэсэн үг вэ гэхээр конкретээр үзэхэд олон спэцикатуудыг зөвшөөрдөг ба тэгсэн хэдий ч Аристотэлын хэлсэнээр сайн амидралын дүр төрхийг илэрхийлж чаддаг. Нэг үгээр хэлбэл тэр дээрхи зорилгын ерөнхий дүрсийг схэмчилдэг. Хэдийгээр агуулгынхаа хувид таамагласан ч гэсэн рэалынхаа хувид тэр ашигтай. Аристотэлчууд судалгаандаа юуг зөв гэдэг вэ гэхээр таамагласан хэллэг зөв байвал тод хэлсэн буруугаас илүү гэдэг. Тиймээс бид нийгэмийн политикин асуудалуудад эрчтэй таамагласан тэорийг хэрэглэдэггүй ч ихэнхидээ тодорхой гэхдээ буруу хариулт авдаг.

Эрчтэй тэори либэралчуудын хэлсэнээр метафизик биш. Энэ тэори нийгэм дэхи хүмүүсийн үнэтүүдийн тухай ойлголттой хамаагүй биш. Энэ бас метафизикийн болон шашины традицад тулгуурлаагүй тэори биш. Тиймээс энэ тэори үнэтүүдийн тухай ойлголтыг хүчтэйгээр тавидаг ба түүхийн дотоод агуулгатай. Түүнээс гадна энэ тэори али болох л бүгдийг хамаруулахыг хичээдэг ба хүмүүс хоорондоо шашины болон метафизикийн ялгаанаасаа хамаарахгүйгээр хэн хэнийгээ танин мэдэж мөн хүлээн зөвшөөрхийг хэлдэг. Бидний харж буйгаар энэ тэорины гарал хүний л концэпцийг илэрхийлнэ. Энэ концэпц Аристотэлийг шүүмжилэгчдийн хэлснээр метафизик биологид суурилаагүй харин янз бүрийн цаг хугацаанд болон янз бүрийн орон зайд болсон хамтын домог болон түүхүүдэд суурилсан ба тэдгээр юу илэрхийлдэг вэ гэхээр дотны болон гадны хүмүүст хүн гэдэг хэнийг илэрхийлдэг. Энэ концэпц хүмүүсийн өөрийн интэрпрэтаки болон өөрийгөө илчилж буй процессуудын үр дүн бөгөөд сайэнсын ухамсар дээр биш харин дээрхи түүхүүд дээр тулгуурласан фантазуудаас гаралтай. Миний түүрүүчийн Аристотэлийн этикийн тухай номонд хүмүүсийн хоорондын дээрх процессыг юу гэж тодорхойлсон бэ гэхээр: нийгэмийн гишүүд өөрсдөдөө болон хүүхэдүүддээ хүний амидралаар амидрах ямар учир утгатай болохыг тодруулсан. Дээрхи түүхийн чухал чадвар юу вэ гэвэл хэдийгээр хүмүүс бие биенээсээ хол амидардаг ч бие биенийгээ адилхан хүн шүү гэж танин мэдэх. Аристотэлийн бичсэнээр: хүмүүс гэрээсээ гараад хол явах үедээ бусад хүмүүсийг хараад хоорондоо хэр адилхан мөн ямар нэг байдлаар садан төрлийн холбоотой гэдгээ мэдэрдэг. / Никомахын этика. 1155 a 21-22/ . Дээрхи эрчтэй таамагласан тэори бас л иймэрхүү хүмүүс хоорондоо садан төрөл шүү гэдэгийг илэрхийлдэг. Энэ тэори нилээд ерөнхий: яагаад гэвэл энэ тэори хүмүүсийн амидралын тодорхой аспектиуд онцгой утгатай гэдэг. Түүнгүйгээр бид өөрсөдийгөө болон бусадыг танихдаа бид хэн байна вэ гэдэгээ таних боломжгүй. Энэ тэори хүмүүс бид хаана мөн хэзээ мөн хэрхэн амидарч буй амидралын ялгаатайг илэрхийлдэг ба өөр өөрсөдийнхөө төрөлийн нэгэн гишүүд шүү дээ гэдэгээ танин мэддэг.

Эрчтэй таамагласан тэорины суури идэй бид хүний амидралын ерөнхий форм болон структууудыг яриж буй шүү дээ гэсэн түүхийг хэлдэг. Бид дараах асуултыг ингэж тавиж бас ингэж хариулдаг: хүн гэдэг төрөлөөр амидрах өөрөөр хэлбэл амитан болон бурхан хоёрын завсар амидрах юу гэсэн утгатай бэ? Энэ хүн хэдийгээр байгалиас тусдаа ч мөн байгалиас хамааран амидарна. Энэ идэй бидэнд ямар төсөөлөлийг өгдөг вэ гэхээр дэлхий дээр хүн гэж амидрах ямар утгатай бэ? Хэрэвээ хүн өөрсдийгөө дээдэс эсвэл доодос гэсэн орон зайд шилжүүлнэ гэвэл бид хүнээ болино. Энэ зөвхөн үлгэр домогт л бичигдэж өнөөг хүрчээ. Хүн биш амитан эсвэл бурхан гэсэн үлгэр домгууд бидний ямар фантазууд мөн ямар асуултууд вэ

гэхээр: нэгэнт л бурхан хүн дүрстэй бол хүмүүс бидэнтэй адилхан хүн гэхгүй бурхан гээд байгаа бэ? Энэ мэтээр хүн бид өөрсөдийгөө хэн гэдэг тухай суралцдаг.

Жишээлбэл Грекийн олимпийн бурхадуудын тухай тоолж барахгүй олон түүхүүдийг бичсэнээр тэдгээр хүнтэй адил зүс царайтай ба зарим бас хүнтэй адил хүсэлтэй, дур сонирхолтой. Гэхдээ тэдгээр үхэшгүй үүрдийн бөгөөд мөн тодорхой зэрэглэлээр хөдлөшгүй. Бид эдгээр дүрслэгдсэн бурхадуудыг төсөөлөх гэвэл бидний хооронд ямар зааг байна вэ гэдэгийг асуух бөгөөд ямар амидралын хэв маягуудыг төсөөлөх боломжтой. Тэгсэнээрээ хүний амидралын тухай ойлголттой болох . Жишээлбэл: Циклопэн гэдэг бурхан хүнтэй адил дүр төрхтэй хэдий ч бусдаас алслагдсан, зожиг амидрах ба тиймээс бусадтай хамтрах болон бусадтай харилцаанд ордоггүй. Үүнийг хүн өөрийнхөө амидралтай харицуулан юу гэж ойлгох вэ гэхээр тэдгээр тэгээд хүн биш гэж үү?

Ийм байдлаар би цааш судлая. Иймэрхүү түүхүүд бусад ард түмэнүүдийн соёлуудад ч тааралдана. Хүний тухай бид энд эцэсийн эцэст нэгэн теорид хүрэх ёстой бөгөөд тэр теори бидний хүний утгыг зөвхөн улс орны дотор ч биш бусад ард түмэнүүдэд зөвшөөрөгдөхөөр тийм теори шаардлагатай. Хэрэвээ тийм биш бол бидний гайхалыг төрүүлээд зогсохгүй дараах асуултыг тавина. Тэгэхээр ямар шинж төрхүүдээр хүмүүс биднийг адилхан гэдэг вэ? Ямар шинж төрхүүдээр хэдийгээр бид ойрхон ч гэсэн адилхан бэ? гэсэн асуултыг тавина.

Шинж төрхүүдийг жагсаасан жагсаалтын хуудас ямар ч л гэсэн нээлттэй байх ёстой. Яагаад гэвэл бидний шинж төрх гэж байсан зүйлээс ялгаатай зүйлс шинээр нэмэгдэж, ялгаанд хамаагүй зүйлс тэр хуудаснаас хасагдах ёстой. өөрөөр бид бас зарим шинж чанаруудыг бусад нийгэмүүдийн хүмүүсээс шаардах ёсгүй бөгөөд яагаад гэвэл тэр хэт явцуурах боломжтой. Бидний энэ хуудас Аристотэлийн зарим хуудасуудтай адил философийн системчилсэн теори биш харин бидний төсөөлөлүүдийн нэгтгэл бөгөөд харин тодорхой дүрэм, горим биш түүний оронд хэн хэндээ анхаарал тависан амидралын чухал салбаруудыг удирдах ёстой интуитив ойртолт . Энэ хуудас зөвхөн интуитив биш бас гэтэрогэн. Яагаад гэвэл энэ хуудас бидний зөрчилөөс холдуулсан хил хязгаартай мөн чадвараа нээх боломжийг агуулдаг. Энэ тийм ч гайхалтай биш яагаад гэвэл бидний хүний тухай анхны төсөөлөлүүд чадварыг болон дур сонирхолыг агуулсан. Энэ цэгтээ бид эргэн очих бөгөөд юуг харуулах вэ гэхээр энэ политикийн хувид ямар нөлөөтэй вэ гэдэгийг харуулна.

Энд би хүний амидралыг амидрал гэж нэрлэхэд юу юу шаардлагатай тухай дүрслэхийг хичээв.

5. Эрчтэй вагэ концепцийн төвшин А: хүмүүсийн конститутив нөхцөлүүд буюу хүний амидралын формуудын суури структур.

Үхэл

Хүн бүрийн өмнө үхэл бий. Хүмүүс амидралынхаа тодорхой нэг цаг үед үхэлийг өмнөө ирсэнийг мэддэг. Хүн үхнэ гэдэг хүний амидралын бусад бүхий л үйл явцыг тодорхойлно. Үүний хажуугаар бүх хүмүүс үхэлийн эсрэг хандлагатай. Хэдийгээр хүмүүсийн амидралд тохиолдох янз бүрийн явцуудад хүмүүс үхсэн дээр гэдэг ч хэрэгдээрээ хүмүүс амидрахыг л хүсдэг. Лукрэтус ч гэсэн анхны үхэхчийнхээ хувид нилээд айж бас зовж, амидралынхаа амтат гэрэлийг унтраадаг. Хэрэвээ бид үхэшгүй нэгэн биеттэй тааралдана гэвэл бидний амидралын хэв маягаас ялгаатай гэж үзэх бөгөөд бидний амидралын нэг хэсэг гэж хэлэхгүй. Үүнтэй адил үхэх ч хүн үхэлээс зугтахгүй. Цаашид амидрахгүйгээр үхэх гээд байвал бас л бидний гайхалыг төрүүлнэ.

Хүний бие

Бид амидралынхаа турш өөрийн гэсэн бие дотороо амидардаг. Тиймээс хүний нийгэмд бид биеийнхээ боломжууд болон гэмтэлүүдийг хэзээ ч бусдын бие мэт эдлэхгүй. Энэ л бидний өөр гэхээсээ илүү адилхан гэгдэх биеүд дотороо нутаглах ба тэдгээр бидэнд боломжуудыг ч олгоно. Мөн боломжууд ч бүтэхгүй. Бид заримдаа өөрийнхөө биед хэт дассанаар бусад биеээс ялгаатайгаа амархан мартаж мөн биднийг боломжоо биелүүлэхэд эсвэл биелүүлж чадахгүй байхад бие ямар их үүрэг гүйцэтгэдэгийг амархан мартдаг. Бид хэн хэнийгээ таниж байгаагийн шалтгаан хүн бүр хаа нэг газар амидарсан. Мөн али нэг зан заншилд хамаарагддагийн гэрч. Тиймээс энэ гэрч хүний биеийн характэруудаас болон бусадын биеэс хэрхэн ялгаатайг илэрхийлнэ. Биеэрээ хүн хэрхэн мэдэрч буй традицаас хамааралтай. Харин бие өөрөө бол традицаас хамааралгүйгээр үүссэн ч хүн бидэнд хил хязгаар болон адил талуудыг мэдрүүлдэг.

Хүмүүсийн мэдэрч буй мэдрэмжүүд хэр их биеээс хамаардаг вэ гэсэн асуултын талаар мэдээж олон саналын зөрөлдөөнүүд бий. Үүнд метафизик багагүй үүрэг гүйцэтгэнэ. Тиймээс би метафизик биш характэруудынх хувид энд метафизикийн дуалистуудын зөвшөөрсөнөөр юуг биетэй хамааруулдаг тухай дурдая. Харин нилээд маргаантай мэдрэмж болон бодолын тухай сэдэвүүдийг тусад авч ярилцана. Тиймээс би дуализмын тухай ярихгүй.

- 1. Өлсөх ба Цангах: Идэх ба уух шаардлага.** Хүн бүр амидрахын тулд иднэ, ууна. Хэдийгээр хүнс тэжээлийн хэлбэр хоорондоо зөрөөтэй ч бүх хүмүүс

ижил төрөлийн зүйлс иддэг. Хэдийгээр ард түмэнүүд хоорондоо ялгаатай ч идэж ууссанаа шингээдэг ходоодны ажиллагаа ижилхэн. Түүнээс гадна хүн бүр аливааг шаардсан дур хүсэлтэй. Юунд дурлаж юуг хүсэх мэдрэмж тодорхой нэг хэмжээнд хүрээд ирэхээрээ тухайн култураас буюу ард түмэнээс шалтгаалан өөрчилөгдөнө. Зарим ард түмэнүүдийн дур хүсэл үнэхээр хүний биеийн шаардсан шаардлагатай тохирдоггүй. Тэгсэн хэдий ч ард түмэнүүдийн хооронд нилээд их ижил төсөөтэй талууд бий. Гэхдээ л хүмүүс ерөнхийдөө өлсөж, цангахаас шалтгаалан зовохыг хүсэхгүй. Аристотэлийн ажигласанаар хэн нэг хүн өлсдөггүй бас цангадаггүй гэвэл өөрөөр хэлбэл юу ч иддэггүй, юу ч уудаггүй гэвэл ийм хүнийг юу гэж шүүх вэ гэхээр хүнээс хол хөндий гэнэ. / Никомахын этик 1119 а 7-10/.

2. **Өөрийгөө хамгаалах шаардлага:** Эртнээс яриж ирсэн домогуудын нэг сэдэв бол хүн нүцгэн тиймээс арчаагүй бөгөөд хэврэгхэн. Юуны эсрэг вэ гэхээр халууны эсрэг мөн хүйтэний эсрэг мөн бусад элэмэнтийн эсрэг. Хүн төрөлхтөний түүхийг харахад хүмүүст юу шаардлагатай, хүн хэн бэ гэдэгийг хэрхэн амархан мэдэх жишээнүүд олон. Жишээлбэл: үстэй дээл болон байлдааны танкууд бидэнд юуг хэлдэг вэ гэхлээр хүн өөрийгөө хамгаалах ямар их шаардлагатайг сануулдаг. Тэр л бидний амидралд хэрэгтэй шаардлагууд хүнийг халуунаас, борооноос, салхинаас, цаснаас болон хүйтэнээс мөн жавараас хамгаалдаг.
3. **Сэксийн дур:** Хэдийгээр сэксийн дур идэж уух болон өөрийгөө хамгаалах шаардлагатай адил эрчтэй биш ч гэсэн хүний амидралын нэгэн шинж. Аристотэл түүнийг хүний шаардлагуудын нэг гэж үзээд хэрэвээ тэр дутагдах бол түүнийг хүн байна гэхээс зааглан үзэх хэрэгтэй гэжээ. Иймэрхүү жишээ хүмүүс бид өөрсдөөсөө л ялгаатай бол хүн мөн үү гэсэн асуулт тавидаг.
4. **Хөдөлгөөн:** Эрт дээр үеэс л эхлээд хүмүүс өөрсдийгөө өдгүй, хоёр хөлт гэсээр иржээ. Энэ юу гэсэн үг вэ гэхээр хүний амидралын хэв маяг али нэг газараас нөгөө газарт хүрч чадах хөдөлгөөнд оршино. Хүн зөвхөн багаж хэрэгсэлийн тусламжтайгаар биш өөрийнхөө төрсөн биеэрээ нэгээс нөгөө рүү хөдөлнө. Хүмүүс хөдөлгөөнд дуртай. Тиймээс хөдөлгөөнийхөө чөлөөг алдахыг хүсдэггүй. Хэрэвээ хүн төрөхөөсөө авахуулаад үхтэлээ хаашаа ч хөдлөхгүй гэвэл мэдээж өвчиний шаардлагаар биш. Тийм хөдөлгөөнгүй хүнийг хүн гэхгүй. Тиймээс ямар ч хөдөлгөөнгүй амидралыг хүний амидрал гэх боломжгүй.

Баярлах ба өвдөхийг эдлэх чадвар

Өвдөх болон баярлахыг эдэлдэг гэдэгээрээ бүх хүмүүс адилхан. Хэдийгээр тухайн културууд болон ард түмэнүүд түүнийгээ илэрхийлж буй хэлбэрүүд тодорхой нэгэн зэрэглэлд хүртэлээ ялгаатай. Түүнээс гадна өвдөхын эсрэг болон өвдөхөөс айх байгалиас гаралтай дутагдал ба түүнийг ажихад хүн түүнийг сураагүй бололтой. Хэрэвээ али нэг нийгэмийн гишүүд өвдөхөөс айхгүй гэвэл тэднийг хүний нийгэмээс гадуур гэж хэлэх .

Мэдрэмж, Төсөөлөл, Бодол гэх мэт чадварууд

Бүх хүмүүс мэдрэдэг мэдрэлийн эрхтэнүүдтэй бас аливааг төсөөлөх мөн бодох чадвартай. Мөн шийдэх чадвартай. Аристотэлийн метафизик номондоо бичсэн алдартай өгүүлбэр хүн бүр мэдлэгийн төлөө зүтгэнэ. Энэ чадварууд хамгийн үнэтэй. Эндээс гарах нэг асуулт бол дээрхи чадваруудаа гэмтэлээр эсвэл сааталаар алдалаа гэвэл ийм хүмүүсийг тэгээд хэн гэх вэ? гэсэн асуулт. Гэхдээ л бид аливаа нэг нийгэмд хүмүүс мэдрэх чадваргүй, төсөөлөх чадваргүй, мөн бодох чадваргүй гэвэл тийм нийгэм бидэнд ямарч харагдсан бай хүний нийгэм гэхгүй.


Нялх хүүхэдийн хөгжил

Хүн бүр төрөхдөө өлсгөлөн ба нялх төрж зөвхөн л бусадын тусламжанд амидарч эхлэн мөн хэн нэгэний ойртолт болон холдолтоос хамааралтайгаа мэдрэнэ. Хэдийгээр ингэж амидралыг адилхан эхэлцгээдэг ч хүүхэдийн хүсэл болон сэтгэл цааш бүрэлдэн тогтоход тухайн ард түмэнүүд ялгаатайгаар нөлөөлдөг. Тиймээс сэтгэлийн хөдөлгөөн өөр өссөн ард түмэний хүүхэдүүд бусдаас ялгагдана. Тиймээс яагаад ялгаатай вэ гэдэг цаанаа гүн утгатай. Түүнийг маргах явдалгүй. Жишээ: нялх хүүхэдийн шаардлагыг Сигмунд Фройд судалсан, мөн Миланы Клайн нялх хүүхэдийн өвдөлт, өнчирөлт болон сэтгэлийн онцлогуудыг судалсан. Тэдний хэлсэнээр хэдийгээр ард түмэнүүд ялгаатай традицтай ч хүн гэдэг утгаараа нялх хүүхэдүүдийн хооронд бага ялгаа ажиглагджээ. Хэрэвээ бид хэзээ ч нялх хүүхэд байж үзээгүй мөн хэзээ ч тэд бусдаас хамааралтай, бусадын шаардлагатай, мөн бусад руу хандлагатай байж үзээгүй гэвэл тийм хүмүүсийг бид хүний амидралаас хол гэх . Ямар ч л гэсэн бидний төрөл гэхгүй.

Үргэлжилэл бий...

Б. Гансүх
Brothers_3399@yahoo.com

Томас Хоббэс



**“Лэвиатан”
буюу
сүмийн ба иргэний төрийн бодис, форм ба
хүчирхийлэл**

Үргэлжлэл...

Хэсэг 1: Хүний тухай

Бүлэг 4: Хэлний тухай

*Номын хэвлэлийн сэдэл хэдий гэниал⁴¹ боловч, түүнийг үсэгний сэдэлтэй харицуулбал хэвшмэл бус гэх зүйл огт үгүй. Гэхдээ, хэн анх үсэгний хэрэглээгээ нээсэн бэ гэдэг тодорхой бус. Хэлэхдээ, Феницийн хаан *Агэнор* -ын хүү *Кадмос* анх Грекд оруулсан гэдэг. Энэ бол өнгөрсний талаарх санамжийг цааш өгөх, тэрчлэн дэлхийн хоорондоо алслагдах нутагаар бутарсан хүн төрөлхтөнийг холбоход ашигтай сэдэл. Хэлний, тагнаан, уруулын болон бусад ярианы багажуудаас, үүгээр мөн л энэ хөдөлгөөний санамжид үйлчлэгдэх олон ялгаатай авиан тэмдэгтүүдийг хөгжүүлэхийн тулд ялгарах ондоо хөдөлгөөнүүдийн анхааралтай ажиглалтаас түүнийг хийхэд хялбар байсангүй. Гэхдээ энэ бүх сэдэлүүдийн хамгаас шижир, хамгаас ашигтай ни нэрнээс эсвэл нэрлэгээнүүдээс, тэрчлэн холбоосуудаас бүрдэх хэлэнд⁴² байсан. Түүнтэй хүмүүс өөрсдийн бодолуудыг тэмдэглэдэг, хэрвээ тэд өнгөрцөн бол, бас хоорондоо харилцан ашигийг болон дискуссд илтгэдэг бол тэрнийг буцааж дуддаг. Тэрэнгүйгээр хүмүүсийн дунд төр ч, нийгэм ч, гэрээ бас энх⁴³ үгүй байхсан - арслан, баавгай ба чоно дундаас огт илүүдэхгүй. Хэлийг анх бүтээсэн ни *бурхан* өөрөө байв, *Адам* өөрт харуулсан бүтээгчидийг нэрлэдэг шиг*

⁴¹ гайхамшигтай;

⁴² ярианы хэл;

⁴³ *engl.*: peace;

сургав, яагаад гэхлээр уг эдэд бичиг цааш явахгүй. Гэхдээ энэ түүнийг амид биетийн туршлага, үзэл, тэрчлэн хэрэглээг санал болгосон боломжид дүйцэхүйц нэрнүүд олшруулахын тулд, мөн түүнийг ойлгомжтойгоор хийж чадагдахаар байн байн тэр төрөлөөр холбохын тулд энэ үйлдэлд хүргэхэд хангалттай байв. Ингэж тэрээр хугацаа өнгөрөх тутам хэлнээс ийм ихийг яг нэг илтгэгч эсвэл философичид зайлшгүй шиг, хэрвээ бас үгээр баялаг бус ч өөрт хэрэглэж чадахаар эзэмшинэ. Яагаад гэвэл би бичигт *Адамд* бүх фигурийн⁴⁴ нэрс, тоонууд, масс,⁴⁵ өнгө, чимээ, төсөөлөл ба харилцаануудыг сургагдсан шиг, ахиад цөөвтөр үгсийн болон илэрхийлэлүүдийн нэрс бүгд хэрэгтэй гэгдэх *нийтлэг, өвөрмөц, тиймлэсэн, үгүйсгэсэн, асуусан, хүссэн, төгсөшгүй*, харин бүгдээс бага хэрэгтэй *бодит*,⁴⁶ *интэнционалити*,⁴⁷ *квидитас*⁴⁸ болон бусад юу ч хэлдэггүй сургуулийн үгс мэт шууд эсвэл шууд бус ч салгагдаж болохуйц юуг ч олж чадашгүй.

Адам болон түүний араас ирэгсэдээс эзэмшигдсэн бас олшруулагдсан бүхий хэл нийт хүмүүс бурханы гараар түүний өмнөх хэлэнд цохигдсон мартагтай хаягдалын төлөө тэр мөчид *Бабэлийн* цамхагт эргээд гээгдэв. Тэд үүгээр ертөнцийн ялгаатай хэсэгүүдэд бутраахад албадлагдсан тул зайлшгүй маягаар тухайн хугацааны хэлнүүдийн ялгаатай ни тэдгээрээс цааш бүх сэдэлүүдийн эх гэгдэх гачигдал тэдэнд сургасан шиг, мөн хугацааны явцад хэлнүүд хаа сайгүй үгсээр баялаг хөгжсөнд ирэх ёстой байв.

Нийтлэгдээ, хэл бидний оюунд тоглогдох үгээр илэрхийлэгдсэн эсвэл бидний бодолын дараалал үгийн дараалалаар шилжигдэх бодолтод хэрэглэгдэнэ, мөн энэ хоёр шалтгааны улмаас. Нэг ни бол бидний бодолын дараалалын дүрслэлт. Тэд бидний санамжаас амархан гулсана, тэгээд бидэнд шинэ ажил хийнэ, гэхдээ тэдгээрээр тэмдэглэгдсэн үгсийн тусламжтайгаар эргээд санамжид буцаад дуудагдах чадвартай. Ингэж нэрнүүд эхлээд санамжийн *анзаарах* эсвэл *таних* тэмдэгт хэрэглэгдэнэ. Ингэснээр олон хүмүүс хэрвээ нөгөө л үгсийг хэрэглэвэл харилцан холбогдол, мөн үгсийн замбараагаар тэд нэг бүр эдийн дор юуг төсөөлж эсвэл тэдгээрийн тухай юу бодож, түүнчлэн юу хүсэж, юунаас эмээж эсвэл ондоо нэг сэтгэлийг агуулах ни ойлгогдох боломжтой. Үүнээс үүдэлтэй уг хэрэглээнийхийг *тэмдэгт* гэж нэрлэдэг. Хэлний өвөрмөц хэрэглээний төрөлүүд ни дараах: Нэгдүгээрт, бид бодлогоширолтоороо дурын, одоогийн эсвэл өнгөрсөн юмны шалтгааныг олох бас юу бидний танихуйгаар одоогийн эсвэл өнгөрсөн юмсыг авчирч эсвэл нөлөөлж чадах тэдний тэмдэлэсэн - товчхондоо, бэлэнүүдийн эзэмшилт. Хоёрдугаарт, бусадад бидний эзэмшсэн танихуйг харуулах, ондоогоор хэлбэл харилцан зөвөлгөө бас сургалгаа. Гуравдугаарт, харилцан туслалцааг боломжтой болгох үүднээс бидний хүсэлийн бас бидний санаархалыг бусадад таниулах. Дөрөвдүгээрт, бид баясал эсвэл чимэглэлд гэм үгүй шинжээр бидний үгстэй наадахдаа бидэнд бас бусадад таалагдах болон баярлуулах.

Энэ хэрэглээнд мөн буруу хэрэглэгээний дөрвөн төрөлүүд харяалагдана. Нэгдүгээрт, хэрвээ хүмүүс үгсийн ганхсан утгаас болж тэдгээрийн бодолыг буруу тэмдэглэвэл. Үүгээр тэд хэзээ ч төсөөлөөгүйг өөрсдийн төсөөлөл мэтээр

⁴⁴ биеийн шэйп;

⁴⁵ жин;

⁴⁶ entity;

⁴⁷ зориуд;

⁴⁸ гол чанар;

тэмдэглэгдэнэ, мөн ингэж өөрсдөө андуурцгаадаг. Хоёрдугаарт, тэд үгсийг шилжигдэх утгаар хэрэглэхдээ, энэ юу гэсэн үг вэ гэвэл, өөрт уридчилж харагдах ондоо нэг учирт, үүгээрээ бусадыг андууруулахад хүргэнэ. Гуравдугаарт, хэрвээ тэд үгсээр ямарвааг өөрсдийн хүсэл мэтээр тайлбарлавал, хэдий тэр ни биш ч гэлээ. Дөрөвдүгээрт, хэрвээ тэд тэднийг харилцан гэмтээхийн тулд хэрэглэвэл. Яагаад гэвэл натур дайсанаа гэмтээж чадахын тулд зарим ни шүдээрээ, зарим ни эвэрээрээ, мөн зарим ни гараараа зэвсэглэсэн амид биетүүдийг, хэрвээ бид түүнийг хэлээрээ гэмтээвэл энэ зөвхөн хэлний буруу хэрэглэгээ - яагаад гэхлээр үүнд бидний үүрэг болгох тэр заавар хэн нэгэний талаар яригдана. Энэ кэйсд⁴⁹ гэмтээлт биш, харин сайжруулах хүмүүжүүлэлт.

Хэл хэрхэн санамжид шалтгаан болон дараалалд үйлчлэх төрөл ба шинж нэрүүдийн болон тэдгээрийн *холбоосуудын* өгөлтөд бүрддэг.

Ганц нэг нэрүүд бол *өөрийн нэрүүд* бөгөөд ганцаар цор ганц юмд хамаарна, *Пэтэр, Йоханнэс, энэ хүн, энэ мод* гэдэг шиг. Заримууд ни олон юмстай *нэгдмэл, хүн, мори, мод* гэдэг шиг. Хэдий зөвхөн нэг нэр боловч, эдгээрийн нэг бүр ни тэдгээрийг бүгдийг хамтад ни авч үзвэл *ерөнхий* гэж нэрлэгдэх ялгаатай ганц юмсын нэр. Тэгэхлээр ертөнц дээр нэрнээс өөр юу ч ерөнхий биш, яагаад гэвэл нэг бүрчлэн нэрлэгдсэн юм болвол индивидуал⁵⁰ бас ганцаар.

Тэдгээрийн квалити⁵¹ эсвэл ондоо нэг акцидэнц⁵² дахи ижилсэлээс болж олон юмсад ерөнхий нэр өгөөгдсөн. Мөн өөрийн нэр зөвхөн цор ганц юмны төсөөлөлд нөлөөлөх зуур ерөнхий нэрс олоны нэг бүрчилснийг санана.

Ерөнхий нэрсийн ганц нэг ни томоохон, бусад ни багавтар бүслүүр эзэмшинэ, хэдийгээр томоохон ни арай багавтар томыгоо бүслэвч, мөн ганц нэг ни ижил бүслүүрээс болон харилцан хамардаг. Ингэснээр жишээлбэл *бие* гэгдэх нэр *хүн* гэдэг үгнээс илүү өргөн утга эзэмших ба хамруулдаг, түүнчлэн тэд харилцан хамруулдаг тул *хүн* бас *ухамсартай* гэгдэх нэрүүд ижил бүслүүрийнх багтаамж. Гэхдээ бид энд нэг нэрийн дор грамматикд шиг үргэлж нэг үг, гагцхүү заримдаа ондоогоор бичихэд олон үгс хамт, ойлгогддоггүйг анхаарах ёстой. Яагаад гэвэл эдгээр бүх үгс: *Хэн өөрийн үйлдэлүүдэдээ улсынхаа хуулиудыг анхаарна*, үгийн *шударга* шиг нөгөө л утгыг илэрхийлэх зөвхөн ганц нэрийг бүтээнэ.

Бид цаашдын болон нягт утгын нэрийг оруулснаар бид тооцоололтыг оюунд зураглагдсан юмсын дагавартайгаар тооцоололт руу нэрэлгээний дагавартайгаар хувиргана. Жишээлбэл, хэрвээ огт яриж чаддаггүй хэн нэгэн, хэл үгүй дүлий төрсөн ба энүүгээрээ үлдэх нэгэний нүдний өмнө гурвалжин тавиад, мөн үүнд баруун өнцөгт фигурийн булан шиг хоёр баруун өнцөгтийг, ингэснээр тэр өөрийн бодлогоширолоор гурвалжингийн гурван өнцөгт нөгөө хажууд байрлах хоёр баруун өнцөгтүүдтэй ижил байхаар адилтгал явуулж бас олж чадна. Харин түүнд өмнөхөөсөө хазайсан формтой⁵³ ондоо нэг гурвалжинг харуулбал тэрээр шинээр зүтгэл гаргалгүй энэ гурвалжины гурван өнцөгт мөн л ялгаа үгүй нэрлэгдсэнтэй адил эсэхийг мэдэж чадахгүй. Харин хэн нэгэн үгнүүдэд хэрэглэхэд бэлэн бол энэ тэнцүүлэл талын уртарга ч биш, түүний гурвалжингийн бусад онцгойгоос ч дагасан

⁴⁹ хэсэгчилсэн ситуац;

⁵⁰ ганцаарчилсан хүн;

⁵¹ чанар;

⁵² бүтэцийн зүй;

⁵³ хэлбэр;

биш гагцхүү зөвхөн шулуун талуудыг болон гурван өнцөгтийг эзэмшсэн, мөн энэ бүх байхаар хэрэгээс яагаад тэр үүнийг гурвалжин хэмээн тэмдэглэсэнийг анзаарна, ингэж тэр мэргэнээр ерөнхий дүгнэлтэнд очсон, өнцөгтийн энэ тэнцүүлэл нэг бүрчилсэн дурын гурвалжинд бүрдэж, мөн түүний нээлт энэ ерөнхий хэрэглээнд баригдсан ерөнхий төгсгөлд ирнэ: *Гурвалжин бүрт гурван өнцөгүүд хоёр тэгш өнцөгттэй тэнцүү*. Ингэснээр нэг ганцаарчилсан кэйсд гаргасан гаргалгаа ерөнхий дүрэм шиг тэмдэглэгдсэн ба санамжид хадгалагдана, бидний оюунд тоглогдох хугацааны болон суурингийн тооцоололт чөлөөлөгдсөн бол биднийг бүх оюуны ажилд, гэхдээ нэгдүгээрхийг тооцолгүйгээр, мөн энэ *энд* ба *одоо* үнэн гэдэгээр хийгдсэн *бүх хугацаануудад* бөгөөд *бүх* газарт үнэн гэж нөлөөлөхийг салгадаг.

Гэхдээ бидний бодолын тэмдэглэлд үгсийн хэрэглээ тоонуудад хаана ч ийм нээлттэй биш. Натураасаа *нэг, хоёр бас гурав* шиг тоот үгсийн эгнээн дараалалыг ямарваа нэг натураасаа сулхан этгээд хэзээ ч цээжлэж чадаагүй, хэдий нэг бүр хонхны цохилтыг тэмдэглэж бас тэрүүхэнд дохиж эсвэл нэг, нэг, нэг гэж хэлэвч, тэр хэзээ ч хэдэн цагийг цохиж буйг мэдэж чадахгүй. Мөн эдгээр тооны нэрнүүд хэрэгтэй биш хугацаа мэт тусах ба тоолохыг хүссэн үед нэг гарынхаа эсвэл хоёр гарынхаа хуруунуудыг хэрэглэхийг нэхэмжилсэн хүмүүс. Мөн үүнээс нэг бүрчлэх ардуудад зөвхөн арван тоот үгс байдаг ни үүдэлтэй ба ганц нэгд бол зөвхөн тав, тэгээд дараагаар эргээд урдаасаа эхэлнэ. Хэрвээ арав хүртэл тоолж чадах хэн нэгэн, тоонууд эгнээгээрээ бус хэлэгдсэн ч, тэрээр төвлөрөлөө гээгээд хэзээ бэлэн болохоо мэдэхгүй. Тэрээр нийлбэр гаргахад, түүнчлэн хасахад, мөн бусад бүх тоон үйлдэлүүдийг үйлдэх чадамж илүү бага болно. Тэгэхлээр үгс үгүй бол тоонуудаар тооцоолох, тэрчлэн нөөцөд эсвэл хүн төрөлхтөн тансаглалын тооцооломжид зайлшгүй хэмжээнүүдээр, хурдуудаар, хүчүүдээр болон бусад юмсаар ямар ч боломж үгүй.

Хоёр нэрүүд бие биетэйгээ дараалалд эсвэл баталгаанд холбогдсон бол, жишээлбэл яг: *Хүн бол амид биет*, эсвэл: *Хэрвээ энэ хүн бол, энэ мөн амид биет*, тэрчлэн хоёрдугаар нэр *амид биет* эхний нэр *хүн* утгачилсан бүгдийг утгачилна, тэгсэний дараагаар баталгаа эсвэл гаргалгаа *үнэн*, ондоо тохиолдолд *худал*. Яагаад гэвэл *үнэн* ба *худал*, хэлний атрибут болохоос юмсын атрибут биш. Хаана хэл үгүй байна, тэнд *үнэн* ч, *худал* ч үгүй. *Эндүүрэл* хэдийд өгөгдөх вэ гэвэл бидний хүлээсэн зүйл ирээгүй үед яаж хэрвээ онодоггүй юуг⁵⁴ хүлээвэл эсвэл болоогүй юуг таамагласан бол байж чадна, гэхдээ эдгээр кэйсуудын алинд ни ч хүн бусадад үнэн биш гэж гомдоллох боломж үгүй.

Бидний баталгаануудад *үнэн* гэдэг нэрсийн зөв дараалалд бүрдвэл, цэвэр *үнэнийг* хайсан хэн нэгэн зайлшгүй маягаар түүгээр хэрэглэгдсэн нэг бүрчлэх нэр утгачилагдах ба түүнийг тохиромжтой байранд байрлуулахыг санах ёстой, эсвэл харин тэрээр үгсэд шувууны урхин дахи шувуу шиг хэлхээс болвол: хэдий их тонгочино, төдий чинээгээр тэр цавуудагдана. Тиймээс гэомэтрт (бурханы өнөөг хүртэл хүнд өршөөлт бэлэглэсэн цорын сайэнсд⁵⁵) үгсийн утгыг тогтоохоос эхэлдэг. Утгын энэ тогтоолтыг *дэфиниц*⁵⁶ гэж нэрлэх ба түүнийг тоолохын эхэнд тавидаг.

⁵⁴ *engl.*: thing;

⁵⁵ мэдлэг судлал;

⁵⁶ тодорхойлолт;

Үүнээс, уридын авторуудын⁵⁷ дэфиницүүдийг шалгах үүднээс болон тэдгээрийг хэрвээ анхааралгүй байрлуулсан байвал нэг бол сайжруулна, үгүй бол өөрөө тэдгээрийг байрлуулах үнэн мэдлэгт тэмүүлэх хүн бүхэнд ямар зайлшгүй ни илэрнэ. Яагаад гэвэл дэфиницүүдийг буруу хэрэглэх эндүүрэгсэд цаашлах тооцоололттойгоор үржигдэх ба хүмүүсийг тэдний эцэст ни харсан ч гэсэн, гэхдээ тэдний алдааны суури байрлах байрнаасаа шинээс тоололгүйгээр зайлуулж чадашгүй дахин шинээр тоолж чадалгүй эргэн учирахуй руу дагуулдаг. Тиймээс тэдгээр номонд найдагсад олон жижиг нийлбэрүүдийг томовтор болгож тоолдог хүмүүс шиг жижиг нийлбэрүүд зөв тоологдсон уу эсвэл үгүй юу гэдэгийг анхааралгүйгээр үйлддэг. Тэд сүүлд алдааг харах ба тэдний эхний суури ухагдахуунуудадаа эргэлздэггүй, ингэснээр тэд шийдэл хүргэх замыг хардаггүй, гагцхүү номнуудынхаа - каминаар орж ирээд нэг өрөөнд түгжигдсэн мэтээр үзэх шилэн цонхны басамжлах гэрэл рүү, яагаад гэвэл тэдэнд ямар замаар орж ирсэнээ тунгаах ойлголт дутмаг тул нисч очоод байдагтай адил намуухан дэвэх шувуунууд шиг нисээд өнгөрөхтэй өөрсдийн хугацааг зарцуулна. Ингэж хэл эхлээд нэрүүдийг зөв дифиницлэхэд хэрэглэгдэнэ: үүн дотор бүх сайэнсуудын эхлэл байрлана. Мөн түүний эхний буруу хэрэглэлгээ буруу хэрэглэгээ худал эсвэл ямар ч дифиниц өгдөггүй буйд оршино. Үүнээс бүх худал бөгөөд учир дутмаг номнуудын ауторитигийн танихуйнуудыг, харин өөрсдийн бодлогоширолоос авах бус, тийм хүмүүсд хоосон сургаалиуд үүснэ, мөн мэдлэггүйчүүдийн дор үнэн сайэнстай танил дээр ни зогсож буйнууд мэт мэдлэггүйчүүдийн дунд аваачдаг. Яагаад гэхлээр мэдлэггүйдэл үнэн сайэнс ба эндүүрсэн сургаалиуд хоорондын дунд байрладаг. Натураасаа мэдрэхүй ба төсөөлөлийн чадал хариуцлага үгүй, анзаарал үгүй, хэнэггүйчүүдийн золиос болдоггүй. Натур өөрөө эндүүрэхгүй, тиймээс тэдгээрийн үгийн баялагийн хэмжээнээс шалтгаалаад хүмүүс нэг бол илүү билигтэй, үгүй бол дундажаас илүү солиотой болцгооно. Уншиж бас бичиж чадахгүй хэн нэгэн төдий чинээ бага онцгой билигтэй эсвэл онцгой танхай болж чадна - гэхдээ, түүний санамж өвчинөөр эсвэл муу эрхтэнүүдийн бүтэц муутгана. Яагаад гэвэл үгс гэдэг зөвхөн тооцоолоход хэрэглэгдэх билигтэнгүүдийн тооны хүрд. Тэд мөнгө ба *Аристотэл, Цицэро, Томас* -ын эсвэл ямар нэг ондоо сургааличийн, хэрвээ энэ зөвхөн хүн л бол, ауторитигийн араас үнэлсэнээр танхайчууд.

Нэрүүдийн зүйл бол бүгд тооцоонд оруулагдах нэг тооцоонд шинжлэгдэх, мөн нэг нийлбэрт тоологдох эсвэл нэг нэгнээсээ хасагдах боломжтой бөгөөд нэг үлдэгдэл гарна. Ромчууд мөнгөн тооцоог “*рационэс*”, тооцоололтыг “*рациоцинативо*” гэж нэрлэсэн бөгөөд бид юуг тооцоонууд эсвэл тооцооны дэвтэр *постууд* гэж тэмдэглэнэ, түүнийг тэд “*номина*” хэмээн нэрлэжээ, энэ ни *нэр* гэсэн үг. Үүнээс тэд “*рацио*” үгийн утгыг бүх ондоо нутагуудаар тэлсэн тооцоолох чадамжид тусгадаг. Грекчүүд *хэл* болон *ухамсарт* зөвхөн “*λόγος*” үгийг хэрэглэдэг. Тэднийг бодсон гэхгүй ч, *ухамсар* үгүй хэл гэж байдаггүй гэдэг, гагцхүү эсрэгээрээ, хэл үгүй бодолт гэж байхгүй. Бодолтын актыг тэд *сэллогизм* гэнэ, юу хэллэгээс нэг ондоог утгачилах дагаваруудын тоолох гэсэн утгатай. Адил юмс харагдахуйц тооцоход ялгаатай акцидэнцүүдтэй болвол тэдний нэрүүд янз янзаар хэрэглэгдэнэ. Хамаарах болж чадах болохоор тэдгээрийн нэрүүд энэ ялгааг харуулахын тулд ялгаатай

⁵⁷ бүтээл туурвигч;

хандагдах бөгөөд зааглагдана. Нэрүүдийн энэ ялгаа дөрвөн классд⁵⁸ эргээд хуваагдах боломжтой.

Эхлээд, нэг юм *матэри*,⁵⁹ эсвэл *биет* гэдэгийнхээ хувид харагдахуйц тооцоологдож чадна, яг л *амид*, *мэдрэмжтэй*, *ухамсартай*, *халуун*, *хүйтэн*, *хөдөлгөөнт*, *тайван* мэт. Энэ бүх нэрүүдээр *матэри* эсвэл *бие* гэгдэх үг илэрхийлэгдэнэ, яагаад гэвэл бүх нэрүүд матэрийнх тул.

Хоёрдугаарт, нэг юм бид түүнд буйгаар төсөөлөх акцидэнц эсвэл квалитигийн харагдахуйцаар тооцоонд тавигдаж эсвэл хэрэглэгдэж чадна, жишээлбэл, *энэ хөдөлж буй* учир, *энэ ийм урт* учираас, *энэ ийм халуун* учираас гэх мэтчилэн. Ингээд дараагаар бид багахан өөрчлөлтөөр эсвэл юмсын нэрнээс хандалтаар хөдөлж биднээр авч үзэгдэх акцидэнц нэр ба *амидтай* гэхийн оронд *ами*, *хөдөлдөгтэй* гэхийн оронд *хөдөлгөөн*, *халуунтай* гэхийн оронд *халалт*, *урттай* гэхийн оронд *уртарга* тоолно. Энэ бүх нэрүүд матэри эсвэл биетээр хоорондоо ялгагддаг акцидэнцийн бөгөөд чанарын нэрүүд. Тэднийг *абстракт нэрүүд* гэнэ, яагаад гэвэл матэрийн тооцооломжоос тусгаарлагдах тул, гэхдээ матэриэс өөрөөс биш.

Гуравдугаарт, бид өөрсдийн биеийн чанаруудаар тооцоолдог, хэдий дараах зааглалуудтай учравч: Хэрвээ бид жишээлбэл, аливааг харвал, тэр юмтай өөртэй ни тооцоолдоггүй, гагцхүү төсөөлөлд буух тэрний тусгал, өнгө ба идэйтэй, мөн хэрвээ бид аливааг сонсвол, зөвхөн бидний зураглал эсвэл чихээр дамжуулагдах ба бүтэх сонсогдсоны төсөөлөлөөс бий болох сонсолт эсвэл чимээ. Тэдгээр ни бидний төсөөлөлийн нэрүүд.

Дөрөвдүгээрт, бид өөрсдөө нэрүүдээр ба *хэлний формуудаар* тооцоолох ба дурсахдаа тэдгээрийг гаргана, бас нэр өгдөг. *Ерөнхий*, *унивэрсал*, *онцгой*, *олон утгатууд* гэдэг нэрүүдийн нэрүүд билээ. Харин *баталгаа*, *асуулт*, *тушаал*, *хүүрнэл*, *сэллогизм*,⁶⁰ *наминчлал*, *үг хэлэх* болон олон бусад хэлний формын нэрүүд. Мөн эдгээр ни орших биет эсвэл оршиж буйгаар төсөөлөгдөж болох тийм, эсвэл орших эсвэл биетүүдийн, эсвэл үгсийн ба хэлний формуудын сэдэгдэх чанарууд натурт бүрдэх эсвэл хүний оюунаас сэдэгдэж болох аливааг тэмдэглэх зориултаар үйлчлэх *ээрэг* нэрүүдийн ялгаатай артууд.

Сөрөг гэж нэрлэгдэх ондоо нэрүүд ч гэсэн бий. Тэд бол үг асуултанд яригдах юмсын нэрүүдийг дүрслэнэ хэмээн илэрхийлэгдэх тэмдэгтүүд, яг эдгээр үгс шиг: *Юу ч биш*, *хэн ч биш*, *төгсөшгүй*, *сургаашгүй*, *гурав бол дөрөвөөс бага* гэх мэтчилэн. Тэгсэн ч тэд тооцоололтын тооцоололт бас сайжруулалтад хэрэглэгддэг, мөн бидний санамж дахи уридын бодолуудыг дууддаг, яагаад гэвэл тэд бидэнд зөв биш хэрэглэгдсэн нэрүүдийг хэрэглэхгүй байхаар шалтгаанжуулдаг, хэдийгээр өөрсдөө юу ч нэрлэдэггүй ч гэлээ.

Бусад бүх нэрүүд бол юу ч илэрхийлдэггүй цуурай, тэрчлэн хоёр янзын арт бий. Нэг ни, хэрвээ тэд шинэ, бас тэдний утга дэфиницээр тайлбарлагдсан тохиолдолд илэрнэ. Энэ арт схоластикэр⁶¹ болон эндүүрсэн философичидоор нөлөөлөгдсөн илүүдэлд байсан.

⁵⁸ ангилал;

⁵⁹ анхдагч биет;

⁶⁰ тоолох;

⁶¹ Догматик сургуули болох үсэгчлэн зааж, асуулт тавиж маргахыг хоридог сургалт;

Нөгөө арт ни, хэрвээ нэг нэрийг зөрчилтэй бас тохиролцох утгын хоёр нэрнээс бүтээвэл, яаж нэр *бие үгүй биет* эсвэл *бие үгүй субстанцтай*⁶² ижилийг, мөн олон бусадыг утгачилвал байна. Баталгаа хэрвээ үргэлж худал бол тэдгээрийн хос бүтэцийн хэсэгүүдийн нэгдэл нэг нэрд ерөөс үгүй гэсэн утгатай. Жишээлэх маягаар *дөрвөн өнцөгт бол бөөрөнхий* гэдэг худал баталгаа, тэгэхээр *бөөрөнхий дөрвөн өнцөгт* гэдэг үг ямар ч утга үгүй, гагцхүү хоосон л нэг цуурай. Хэрвээ эрдэм цутгагдаж эсвэл агааржуулагдаж чадна гэж хэлэх ни худал бол *цутгагдсан* эсвэл *агааржуулагдсан эрдэм* гэх үгс яг адил абсурд⁶³ бөгөөд *бөөрөнхий дөрвөн өнцөгт* шиг л юу ч хэлэшгүй. Тийм болхоор чи барагалж латин эсвэл грэк гаралтай нэрнээс бүтээгдсэн учир битүүлэг бас юу ч илэрхийлдэггүй үг онохгүй. Франц хүн бидний аврагчийн тэмдэглэлд *парол*⁶⁴ гэсэн нэрийн ховор сонсдог бол *вэрб*⁶⁵ -ийг харин тогтмол. Гэхдээ *вэрб*, *парол* хоёр нэг ни латин, нөгөө ни франц үг гэдэгээрээ ялгагдахаа болисон.

Хэрвээ хүн яриаг сонсоод бодол хийлээ гэвэл, мөн энэ яраны үгнүүдийн нэр тэдгээрийн тэмдэглэлд тухайн яриан үгсийг болон тэр яриаг ойлголоо гэж хэлдэг, яагаад гэвэл ойлгох гэдэг ярианаас шалтгаантай төсөөлөл. Тийм болхоор хэл хүний өөрийн хувийн, миний мэдсэнээр ч гэсэн, түүнд ойлголт ч гэсэн хувийнх. Тийм болоод абсурд бөгөөд худал баталгаанууд, ерөнхий бол ойлгогдоггүй, хэдийгээр олонхи ойлгосон гэдэг ч, тэд эдгээр үгсийг аяархан давтах эсвэл цээжлэсэн бол ойлгосон мэт сонсогддог.

Илэрхийлэлүүдийн артуудад, татагдалууд, хөндийрэлүүд бас хүний оюуны ядалууд тэмдэглэнэ, мөн тэдгээрийн хэрэглээгээ бас буруу хэрэглээг би ядалуудын ажиллагааг ярихад хүрнэ.

